



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Санхүүгийн аудитын тайлан

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН 2017 ОНЫ ОРОН НУТГИЙН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН АУДИТ



2018 он

АГУУЛГА

Аудитын нэр, код	3
Аудит хийх үндэслэл, бүрэн эрх	3
Аудитын зорилт	3
Хамрах хүрээ	3
Үндсэн мэдээлэл	3
Эрсдэлийн үнэлгээ	4
Аудитын арга зүй	4
Аудитад ашиглах хууль, тогтоомж, шалгуур үзүүлэлт	4
Аудитын хугацаа	5
Аудит хийх багийн бүрэлдэхүүн	5
Аудитын тайлангийн бүтэц, түүнд тусгахдах мэдээлэл, хэлэлцүүлэх	
Аудитад шаардагдах нөөц, хөрөнгө	5

Товчилсон үгийн жагсаалт

ИТХ	Иргэдийн төлөлөгчдийн хурал
ИТХТ	Иргэдийн төлөлөгчдийн хурлын тэргүүлэгчид
ЭМС	Эрүүл мэндийн сайд
НХХС	Нийгмийн хамгаалал хөдөлмөрийн сайд
БСШУЯ	Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам
ССАЖС	Соёл спорт аялал жуучлалын сайд
ССАЖГ	Соёл спорт аялал жуучлалын газар
ЗТБХБС	Зам тээвэр барилга хот байгуулалтын сайд
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ХААА	Худалдан авах ажиллагааны алба
НТБТ	Насан туршийн боловсролын төв
МШУТ	Мэдээлэл шуурхай удирдлагын төв
СХДА	Санхүүгийн хяналт дотоод аудит
ХГБХХХ	Хүүхэд гэр бүл хүний хөгжлийн хэлтэс
ХДТ	Хөгжимт драмын театр
ЭМТ	Эрүүл мэндийн төв
ЖМС	Жижиг мөнгөн сан
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
НББ	Нягтлан бодох бүртгэл
НББОУС	Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
ОН	Орон нутаг
ОНӨААТҮГ	ОН-ийн өмчит аж ахуйн төсөвт үйлдвэрийн газар
ОНӨҮГ	ОН-ийн өмчит үйлдвэрийн газар
ОНХО	ОН-ийн хөрөнгө оруулалт
ОНХС	Орон нутгийг хөгжүүлэх сан
СТОУС	Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт
СХС	Сум хөгжүүлэх сан
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт
УТХО	Улсын төсвийн хөрөнгө оруулалт
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
ЗГМУС	Засгийн газрын мэдээлэл удирдлагын систем

Нэг. Ерөнхий зүйл

Аудит хийсэн үндэслэл, хугацаа

Аймгийн Аудитын газар Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.4 дахь заалтыг хэрэгжүүлэх зорилгоор Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.3-д заасан бүрэн эрхийн дагуу ОН-ийн төсвийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийлээ.

Аудитын зорилт, хамарсан хүрээ

ОН-ийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт болон бусад шаардлагын дагуу бэлтгэж, ажил гүйлгээ нь түүнийг зохицуулж буй хууль, тогтоомжийн хүрээнд хийгдэж, үнэн шударга илэрхийлэгдсэн эсэх талаар үндэслэлтэй баталгаагаар хууль тогтоох байгууллагыг хангахад энэхүү аудитын зорилт чиглэгдлээ.

Орон нутгийн санхүүгийн нэгтгэсэн тайлан нь иж бүрэн бөгөөд үнэн зөв болохыг тодорхойлсон батламж мэдэгдэл, тайлбар, нэмэлт тодруулгыг тэдгээр тайланд хавсаргах ёстой. Эдгээр мэдээллийг Аудитын олон улсын стандартын дагуу сорьж шалгах нь аудитын зорилт бөгөөд хамарсан асуудлууд болно.

Аймгийн Аудитын газар ОН-ийн төсвийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийж, санал дүгнэлт гаргахын өмнө Төсвийн тухай болон Төрийн аудитын тухай хуулийн дагуу ОН-ийн төсвийн ерөнхийлөн захирагчдын 2017 оны санхүүгийн тайланд аудит хийж, дүгнэлт гаргасан болно.

Аудитын арга зүй

ОН-ийн төсвийн санхүүгийн нэгтгэсэн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй баталгаа олж авахын тулд санхүүгийн тайланг бэлтгэхэд баримталсан бодлого, зарчмыг үнэлж, хяналтын сорил, шинжилгээний горим болон нарийвчилсан сорил хийж, ихээхэн дүнтэй ажил гүйлгээ, тооцооллыг давтан шалгаж, санхүүгийн тайлан, түүний тодруулгад үнэлгээ өгөв.

Ингэхдээ санхүүгийн тайлангийн батламж мэдэгдлийг үндсэн шалгуур болголоо.

ОН-ийн 2017 оны санхүүгийн тайланг нэгтгэхэд баримталсан бодлого, аргачлал

ОН-ийн ТЕЗ-ийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг бэлтгэхдээ УСНББОУС-д заасан зарчим, Сангийн сайдын 2015 оны 341 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайланг бэлтгэж гаргах аргачлал”-ыг баримтлан, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6.1 дэх заалтуудын дагуу нягтлан бодох бүртгэлээ аккруэл сууриар хөтөлсөн байна.

ОН-ийн санхүүгийн нэгтгэсэн тайланд дараах тайлангуудыг нэгтгэсэн байна. Үүнд:

- ОН-ийн төсвийн төвлөрүүлэн захирагчдын 19 санхүүгийн нэгтгэсэн тайлан
- Төсөвт байгууллагуудын 2017 оны 160 санхүүгийн тайлан
- ОН-ийн өмчит үйлдвэрийн газрын 2017 оны 3 санхүүгийн тайлан
- ЭЭСангуудын 18 сумын 2017 оны санхүүгийн тайлан
- Төсөл, сангуудын 2017 оны 40 санхүүгийн тайлан

ТЭЗ-ийн нэгтгэсэн тайланг “Pree balance” программ ашиглан ЗГМУС дэх байгууллага бүрийн эдийн засгийн ангиллаар гарсан зарлагын гүйлгээтэй тааруулан нэгтгэсэн байна.

ОН-ийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дараах бүрэлдэхүүнтэй:

Хүснэгт 1

А. Үндсэн тайлан:	Б. Байгууллагын төрлөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан	В. Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн тайлбар, тодруулга
ОН-ийн санхүүгийн байдлын нэгтгэсэн тайлан	Байгууллагын төрлөөрх санхүүгийн байдлын тайлан	НББ-ийн бодлого, зарчим
ОН-ийн санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлан	Байгууллагын төрлөөрх санхүүгийн үр дүнгийн тайлан	Толилуулгын суурь
ОН-ийн мөнгөн гүйлгээний нэгтгэсэн тайлан	Байгууллагын төрлөөрх мөнгөн гүйлгээний тайлан	
ОН-ийн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн нэгтгэсэн тайлан	Байгууллагын төрлөөрх цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	

Хоёр. Санхүүгийн дотоод хяналт

Тайлант онд Төсвийн тухай хууль бүрэн хэрэгжиж эхэлснээр төсвийн ерөнхийлөн захирагчдын бүтцэд дотоод аудитыг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий нэгж байгуулагдсан байна.

Засгийн газрын 2014 оны 327 тоот тогтоолыг үндэслэн аймгийн Засаг даргын 2014 оны Б/28 тоот захирамжаар Санхүүгийн аудитын албыг байгуулсан. Аймгийн Засаг даргын 2014 оны А/451 тоот захирамжаар албаны дүрмийг батлан үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

Дотоод аудитаар нийт 1538.4 сая төгрөгийн 36 зөрчлийг илрүүлж, зөрчлийг засаж залруулах 159.7 сая төгрөгийн акт, 1378.7 сая төгрөгийн албан шаардлага, 89 заалт бүхий 10 зөвлөмж хүргүүлж бүрэн хэрэгжүүлсэн байна.

Төрийн сангийн хэлтсийн дарга, ерөнхий нягтлан бодогч, дотоод хяналтын мэргэжилтэн нар нь төлбөр тооцоог баримт бүртэй тулган баталгаажуулж, сум байгууллагын гүйлгээг дотоод сүлжээгээр хяналт тавин ажиллажээ.

Гурав. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн дагуу төсвийн болон улс, ОН-ийн өмчийн хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах зорилгоор төсвийн удирдлагын шийдвэр, үйл ажиллагаа ил тод, нээлттэй, ойлгомжтой байх, түүнд олон нийт хяналт тавих мэдээллийн тогтолцоог хуулийн дагуу явуулахаас гадна салбарын хэмжээнд хяналт тавьж ажиллахаар заасан.

Аудитад Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсэгт заасан хуулийн этгээд, төрийн байгууллагыг 2015, 2016 онуудад хийсэн аудитын дүн, мэдээлэлд үндэслэн шилэн дансны мэдээлэл 100 хувийн хэрэгжилттэй Төсвийн ерөнхийлөн захирагчид болон

тэдгээрийн харьяа байгууллагуудад итгэл үзүүлэн аудитаас чөлөөлж, хэрэгжилт хангалтгүй байгууллагуудыг түүвэрлэн 2016 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс 2017 оны 10 дугаар сарын 01-ний өдрийг хүртэлх хугацааны Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг шалгав.

Шалгалтын дүн мэдээнээс үзэхэд Өвөрхангай аймагт Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт хангалттай байгаа ч хөндлөнгийн хяналтыг сайжруулах шаардлагатай байна гэсэн дүгнэлт өгсөн байна. Үүнд:

- Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1-д заасан байгууллагууд бүрэн хамрагдаж, хуулийн 5 дугаар зүйлд заасан шаардлагыг хангаж ажилласан байна.
- Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1-д заасан байгууллагууд 6 дугаар зүйлд заасан мэдээллийг бүрэн мэдээллэсэн байна.
- Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд төсвийн ерөнхийлөн захирагч хяналт тавьж ажилласан ч бүх шатны хурал, иргэд хөндлөнгийн хяналтыг хэрэгжүүлээгүй байна.
- Өмнөх аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлсэн байна.

Дөрөв. Материаллаг байдлыг тодорхойлох

ОН-ийн ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитын гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлыг 2017 оны санхүүгийн гүйцэтгэлийн нэгтгэсэн тайлангийн нийт зарлагын дүнг суурь болгон авч түүний 1.0 хувиар тооцон 1185.1 сая төгрөгөөр тогтоов.

Тав. Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн талаар

ОН-ийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд бүх Төсөвт байгууллага, Төрийн сан, ОН-ийн өмчит үйлдвэрийн газар, Төсөл, сангуудын нэгтгэлийн дүнг тус тусад нь баганаар харуулжээ.

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.4-д заасны дагуу аймгийн төсвийн ерөнхийлөн захирагч жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг жил бүрийн 4 дүгээр сарын 01-ны дотор төрийн аудитын төв байгууллагад хүргүүлэх” гэж заасны дагуу ААГазарт 2018 оны 04 дүгээр сарын 11-нд ирүүлсэн боловч аудитын явцад ОН-ын ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлан 1 удаа засагдаж, доорх залруулгуудыг хийв. Үүнд:

- Аймгийн төрийн сангийн арилжааны банканд дахь нэмэлт санхүүжилтийн 2017 оны эцсийн үлдэгдэл 15.5 сая төгрөгийг кассын үлдэгдлээр тайлагнасан байсныг залруулан бүртгэсэн.
- ГБХХТөвийн санхүүгийн тайланд "Дөлгөөн хайрхан-Уул аудит " аудитын компани аудит хийж 19.9 сая төгрөгөөр үндсэн хөрөнгө орлого авахуулж залруулга хийгдсэн боловч тайланг дутуу нэгтгүүлсэн байсныг залруулан бүртгэсэн.
- Бат-Өлзий сумын Соёлын төвийн барилгын санхүүжилтэд орон нутгийн төсвөөс 2017 онд 579.9 сая төгрөгийг олгосон боловч гэрээний үнийн дүнгийн 949.9 сая төгрөгөөр орлого авч 369.9 сая төгрөгөөр илүү бүртгэсэн байсныг залруулан бүртгэсэн.

Аудитын явцад материаллаг хэмжээний 405.3 сая төгрөгийн алдаа зөрчлийг залруулсан. Энэ нь залруулгын дүнг дансуудаар задалсан алдаа зөрчлийн дүнд оруулж тооцсон болно.

ОН-ийн ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэгдсэн түүвэрт хамрагдсан 5 (Аймгийн ЗДТГ, БОАЖГазар, Санхүүгийн аудит дотоод хяналтын алба, Сум дундын ойн анги, ХДТеатр) байгууллагын санхүүгийн тайланд хийсэн аудитаар материаллаг хэмжээний 0.7 сая төгрөг , материаллаг бус 29.0 сая төгрөг , нийт 29.7 сая төгрөгийн алдаа зөрчил илрүүлснээс 0.5 сая төгрөгийн алдаа зөрчлийг залруулж, 29.2 сая төгрөгийн алдааг залруулаагүй байна. Аудитаар 4 зөвлөмж өгч, 0.6 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага өгсөн байна. Энэ дүнг мөн доорхи дансуудаар задалсан дүнд оруулсан.

ОН-ийн ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэгдсэн сумдын төрийн сангаас бусад БТСГ, ГБХХТөв, Мүзей, МШУТөв, “Мэргэд” сургууль, Онги-Ус суваг, Хархорин –ус суваг, 18 сумын ЭЭСангууд зэрэг 25 төсвийн байгууллага болон аж ахуй нэгжийн 2017 оны санхүүгийн тайланд аудит хийж бие даасан дүгнэлт гаргахад эдгээр байгууллагууд зөрчилгүй дүгнэлт авчээ.

ОН-ийн ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэгдсэн аймгийн ИТХурал, ГХБХБГ, Номын сан, НТБоловсрол төв, Орон нутгийн өмчийн газар, ГБХЗХГазар зэрэг 6 байгууллагын 2017 оны санхүүгийн тайланд итгэл үзүүлсэн байна.

Зургаа. Мөнгөн хөрөнгийн бүртгэл, тайлагнал

6.1 Мөнгөн хөрөнгийн бүтцийн талаар

ОН-ийн ТЕЗ-ийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгөнд дараах зүйлсийг бүртгэж тайлагнасан байна. Үүнд:

- ОН-ийн төрийн сангийн дансны үлдэгдэл, арилжааны банкуудад байршдаг зарим төсвийн байгууллагын жижиг мөнгөн сангийн үлдэгдэл, ОНӨҮГ-ууд, төсөл сангийн харилцах дансдын үлдэгдэл
- Кассад байгаа бэлэн мөнгө.

ОН-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 2016 оны эцэст 3345.0 сая төгрөг байснаас 21.0 сая төгрөгөөр өсч 3366.0 сая төгрөгөөр тайлагнагдсан бөгөөд үүний 5.6 хувь буюу 189.0 сая төгрөг нь арилжааны банкинд байршиж байна.

ОН-ийн төсвийн мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн 2017 оны үлдэгдлийг бүтэц, байгууллагын төрлөөр харуулбал:

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Кассад байгаа бэлэн мөнгө	Хүснэгт 2 (сая төгрөгөөр)	
				Банкинд байгаа бэлэн мөнгө	Төрийн сангийн нэгдсэн данс
			Арилжааны банк		
Кассад байгаа бэлэн мөнгө	38.2	4.9	4.9		
Төгрөг/ЖМС	38.2	4.9	4.9		

**ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН 2017 ОНЫ САНХҮҮГИЙН
НЭГТГЭСЭН ТАЙЛАНД ХИЙСЭН САНХҮҮГИЙН АУДИТ**

Банкинд байгаа бэлэн мөнгө	3306.8	3361.1	-	189.5	3171.6
Төгрөг	3306.8	3361.1		189.5	3171.6
Нийт мөнгөн хөрөнгийн дүн	3345.0	3366.0	4.9	189.5	3171.6
Үүнээс байгууллагын төрлөөр харуулбал:					
Төрийн сан	1869.4	1675.6			1675.6
Техник хяналтын барьцаа	428.1	289.2			289.2
Төсөвт байгууллагууд	45.9	6.8		6.8	
ОН-ын өмчит үйлдвэрийн газар	120.4	187.6	4.9	182.7	
Төсөл, сангууд /ОНХСан орсон/	881.2	1206.8			1206.8

Оны эхний үлдэгдэлтэй харьцуулбал, Төсвийн болон төрийн өмчит аж ахуй нэгжүүдийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 28.1 сая төгрөгөөр өссөн байхад төрийн сангуудын мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 332.7 сая төгрөгөөр буурч, төсөл сангуудын үлдэгдэл 325.6 сая төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна.

6.2 Банкин дахь ОН-ийн харилцах дансны талаар

Төрийн сангийн сүлжээний 2017 оны 12 сарын 31-ны хуулгаар гарсан мөнгөн хөрөнгийн 3171.6 сая төгрөгийн 62 дансны үлдэгдэл, арилжааны банкны 189.5 сая төгрөгийн 43 дансны үлдэгдлийг нэгтгэсэн тайлангийн үлдэгдэлтэй тулган шалгаж 15.5 сая төгрөгийн залруулга хийгдсэн.

6.3 Мөнгөн хөрөнгийн дансанд илэрсэн зөрчлийн талаар

ОН-ын төсвийн байгууллагуудад хийсэн аудитаар анхан шатны бүрдэл дутуу баримтаар гүйлгээ хийсэн, харилцах дансны боловсруулалт хийгээгүй, бэлэн мөнгөний тайланг батлагдсан маягтаар сар бүр тайлагнадаггүй, бэлэн мөнгөний орлого зарлагын баримтыг хөтлөөгүй, төрийн сангийн харилцах дансны үлдэгдлийг зөрүүлсэн, санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүдийг төгрөгөөр илэрхийлээгүй мянгачилж гаргасан, бэлэн мөнгөөр суутгаж авсан ХХОАТ-ын төлөлтийг санхүүгийн тайланд тусгаагүй зэрэг зөрчлүүд гарсан байна. Мөнгөн хөрөнгийн зарцуулалт, үлдэгдлийн баталгаажуулалт, санхүүгийн тайлангийн үнэн зөв илэрхийлэгдсэн байдал, санхүүгийн сахилга, хариуцлагатай холбоотой дор дурдсан нийтлэг зөрчил илэрсэн байна.

Орон нутгийн төсвийн байгууллагууд болон нэгтгэсэн санхүүгийн тайланд хийсэн аудитаар мөнгөн хөрөнгийн данстай холбоотой **32.1 сая төгрөгийн** зөрчил илэрч 20.7 сая төгрөгийн алдаа зөрчлийг аудитын явцад залруулж 11.4 сая төгрөгийн алдаа зөрчлийг залруулах боломжгүй гэж үзсэн байна. Үүнээс: 8.4 сая төгрөгийн алдаа зөрчил нь материаллаг бол 3.0 сая төгрөгийн алдаа зөрчил нь материаллаг бус байна.

Дээрх алдаа зөрчил нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", НББ-ийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно" гэсэн заалтууд, Сангийн сайдын 2012 оны 276 дугаар тушаалын 7.4-т "Нягтлан бодогч нь төсвийн гүйцэтгэлийн болон сар бүрийн мэдээ тайлан харилцагч Төрийн санд ирүүлэхдээ МГТ1 маягтаар тухайн сарын эцсийн

**ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН 2017 ОНЫ САНХҮҮГИЙН
НЭГТГЭСЭН ТАЙЛАНД ХИЙСЭН САНХҮҮГИЙН АУДИТ**

өдрөөр тасалбар болгон бэлэн мөнгөөр хийгдсэн зарлага санхүүжилтийн тайланг төлбөрийн картын дансны хуулгын хамтаар хавсаргаж ирүүлнэ", гэсэн заалт, Сангийн сайдын 2012 оны 77 тоот тушаалын 1-р хавсралтаар батлагдсан "Аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх зааврын 1.4-д "Санхүүгийн тайлан тодруулгын үзүүлэлтийг төгрөг, мөнгөөр илэрхийлнэ" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Тухайлбал: Уянга сумын ЗДТГ, Есөнзүйл, Уянга сумдын Соёлын төв, Хархорин сумын өрхийн эмнэлэг, ЗБ-Улаан сумын СХСан, ББ-Улаан, Есөнзүйл, Бүрд, Өлзийт, Тарагт, Богд сумдын ЭЭСан, ББ-Улаан сумын Төрийн сан, Туяа бага сургууль, Арвайхээр ТҮК, ББ-Улаан сумын ЭМТөв зэрэг байгууллагууд байна.

Долоо. Авлага, урьдчилгааны бүртгэл, тайлагнал

7.1 Авлагын бүтэц, бүрэлдэхүүний талаар

ОН-ийн ТЕЗ-ийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд нийт авлагын эхний үлдэгдэл 6753.4 сая төгрөг байснаас тайлант онд 47.1 сая төгрөг буюу 0.7 хувиар буурч, оны эцэст 6706.3 сая төгрөгөөр тайлагнагдсан. Ажиллагчидтай холбогдсон авлага 14.9 хувь буюу 2.9 сая төгрөг, татаас санхүүжилтийн авлага 28.0 сая төгрөгөөр өссөн байна.

Нийт авлагын үлдэгдлийг бүтцээр нь харуулбал:

Хүснэгт 3

Дансны нэр, төрөл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Зөрүү	Хувиар
Ажиллагчидтай холбогдсон авлага	19.5	22.4	2.9	14.9
Төлбөртэй үйлчилгээний авлага	15.3	7.9	-7.4	-48.3
Татаас, санхүүжилтийн авлага		28.0	28.0	100
Зээлийн хүүгийн авлага	193.8	171.9	-21.9	-11.3
Татвар, НДШ-ийн авлага /ТӨҮГ/	14.5	4.7	-9.8	-67.5
Байгууллагаас авах авлага	312.8	267.1	-45.7	-14.6
Хувь хүмүүсээс авах авлага	6197.5	6204.2	6.7	0.1
НИЙТ ДҮН	6753.4	6706.3	-47.1	0.7

Нийт авлагыг сум тус бүрээр хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 4

Сумдын нэрс	Эхний	Эцсийн	Зөрүү	Хувиар
	үлдэгдэл	үлдэгдэл		
Баян-Өндөр	272.0	250.0	-22.0	-8.0
Бүрд	296.7	271.7	-25.0	-8.4
Бат-Өлзий	285.9	264.5	-21.4	-7.4
Баруунбаян-Улаан	186.5	179.2	-7.4	-4.0
Баянгол	209.4	207.4	-2.0	-0.9
Гучин-Ус	165.0	223.9	58.9	35.7
Есөнзүйл	228.7	315.8	87.1	38.0
Өлзийт	279.9	344.5	64.6	23.1
Зүүнбаян-Улаан	82.1	122.4	40.3	49.1
Богд	241.0	219.9	-21.1	-8.7
Нарийнтээл	227.5	228.6	1.1	0.5
Сант	396.2	302.1	-94.1	-23.7

**ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН 2017 ОНЫ САНХҮҮГИЙН
НЭГТГЭСЭН ТАЙЛАНД ХИЙСЭН САНХҮҮГИЙН АУДИТ**

Тарагт	253.8	250.1	-3.8	-1.5
Төгрөг	150.4	188.9	38.5	25.6
Уянга	382.0	416.0	34.0	8.9
Хайрхандулаан	230.9	234.9	4.0	1.7
Хужирт	437.3	405.8	-31.5	-7.2
Хархорин	1268.4	1044.1	-224.3	-17.7
Арвайхээр	1062.3	1100.6	4.4	0.4
Аймгийн төв	97.4	136.1	38.7	39.7
Нийт	6753.4	6706.3	-47.1	0.7

Дээрх хүснэгтээс үзэхэд Гучин-Ус, Есөнзүйл, Өлзийт, Нарийнтээл, Арвайхээр, Төгрөг, Уянга, Хайрхандулаан, аймгийн төвд авлага 1.1-87.9 сая төгрөгөөр өссөн бол бусад сумдад буурсан байна

7.2 Урьдчилгаа дансны бүтэц, бүрэлдэхүүний талаар

ОН-ийн ТЕЗ-ийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд нийт урьдчилгааны эхний үлдэгдэл 581.8 сая төгрөг байснаас тайлант оны эцэст 909.1 сая төгрөгөөр тайлагнагдаж 327.3 сая төгрөгөөр өссөн. Энэ нь үндсэн хөрөнгө бэлтгэхтэй холбоотой урьдчилгаа тооцоо үүссэнтэй холбоотой байна. Тухайлбал: Арвайхээр сумын 150 хүүхдийн цэцэрлэгийн барилгын урьдчилгаа санхүүжилт 263.0 сая төгрөгөөр нэмэгдсэнтэй холбоотой байна.

7.3 ОН-ийн ТЕЗ-ын авлагын талаар илэрсэн зөрчил

Аймгийн төсөвт болон ОН-ийн өмчит аж ахуйн нэгж, байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар авлагын данстай холбоотой **нийт 35.6 сая төгрөгийн** алдаа зөрчил илэрсэн байна. Үүнээс 28.0 сая төгрөгийн алдааг аудитаар залруулж, 7.6 сая төгрөгийн алдаа зөрчлийг залруулаагүй байна. Залруулагдаагүй алдаа зөрчлийн 2.2 сая төгрөгийн алдаа зөрчил нь материаллаг бол 5.4 сая төгрөгийн алдаа зөрчил нь материаллаг бус байна. Нийт алдаа зөрчлийг ангилбал:

- Гучин-Ус, Зүүнбаян-Улаан, Уянга, Нарийнтээл. Баянгол сумдын СХСан, Уянга сумын ИТХ, ЗДТГ, Арвайхээр сумын ЕБ-ийн 4-р сургууль зэрэг байгууллагууд 24.8 сая төгрөгийн авлагыг санхүүгийн тайланд зөрүүтэй тусгасан байгаа нь нийт зөрчлийн 69.9 хувийг эзэлж байна.
- Зүүнбаян-Улаан сумын ИТХ, Бүрд сумын ЭЭСан, Уянга сумын ЕБ-ын 2-р сургууль зэрэг байгууллагууд 2.1 сая төгрөгийн авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байгаа нь нийт зөрчлийн 5.9 хувийг эзэлж байна.
- Арвайхээр, Богд, Төгрөг сумдын СХСангууд 8.6 сая төгрөгийн зээлийн хүүгийн орлогыг зээлийн нийт хугацаанд хуримтлуулан бүртгэж, зээлийн авлага, хүүгийн авлага дансыг тус тусад нь илэрхийлээгүй байгаа нь нийт зөрчлийн 24.2 хувийг тус тус эзэлж байна.

Дээрх байдал нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккруэл сууриар хөтөлнө", 14 дүгээр зүйлийн 14.4 дэх "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ", 14.4.2 дахь "бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага" заалт, 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" заалтыг тус тус зөрчсөн байна.

7.4.ОН-ийн ТЕЗ-ын урьдчилж гарсан тооцооны талаар илэрсэн зөрчил

Урьдчилж гарсан тооцоо данстай холбоотой нийт **25.6 сая** төгрөгийн алдаа зөрчил илэрч аудитаар залруулсан байна. Нийт алдаа зөрчлийг ангилбал:

- Өлзийт сумын ЕБС-ийн урсгал засварын зардалд 10.0 сая төгрөг, Баян-Өндөр сумын ОНХСангаас сумын хогийн төв цэг цэгцлэх, талбайг багасгах зардалд 5.4 сая төгрөг, Есөнзүйл сумын ОНХСангаас өндөр хурдны интернетийн үйлчилгээ оруулах ажилд 10.2 сая төгрөгийг тус тус шилжүүлж ажлыг хийж гүйцэтгээгүй байхад урьдчилж гарсан зардлын дансаар бүртгээгүй байна.

Энэ нь УСНББОУС 17, СС-ын 2006 оны 388 дугаар тушаалаар батлагдсан дансны зааврыг зөрчин, санхүүгийн тайлангийн хэмжилт, тохируулга, тохиолдсон байх гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй, санхүүгийн тайланг буруу илэрхийлсэн байна.

Найм.Бараа материалын бүртгэл, тайлагнал

8.1 Бараа материалын бүтэц, бүрэлдхүүний талаар

ОН-ийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд нийт бараа материалын эхний үлдэгдэл 4910.4 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 5486.0 сая төгрөгөөр тайлагнагдаж, тайланд онд 575.6 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 5
(сая.төгрөгөөр)

Бараа материалын нэр	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Зөрүү	Хувь
Тусгай зориулалтын материал	728.5	843.1	114.6	15.7
Эм боох материал	270.6	238.2	-32.4	-11.9
Дуусаагүй үйлдвэрлэл	1.7		-1.7	-100
Бэлэн бүтээгдэхүүн	117.4	122.4	5.0	4.2
Бичиг хэргийн материал	67.1	77.0	9.9	14.7
Аж ахуйн материал	1522.2	1695.7	173.5	11.4
Сэлбэг хэрэгсэл	34.3	50.8	16.5	48.1
Түлш шатахуун, тослох материал	30.1	36.7	6.6	21.9
Барилга засварын материал	41.9	56.6	14.7	35.0
Хүнсний материал	447.4	462.9	15.5	3.4
Бусад хангамжийн материал	1030.9	1206.0	175.1	16.9
Мал амьтад	222.1	211.7	-10.4	4.7
Нөөцийн бараа	396.1	484.9	88.8	22.4
НИЙТ ДҮН	4910.4	5486.0	575.6	11.7

Бараа материалын өсөлт, бууралтыг нэр төрлөөр нь авч үзвэл тусгай зориулалтын материал, бэлэн бүтээгдэхүүн, бичиг хэрэг, сэлбэг хэрэгсэл, түлш шатах тослох материал, барилга засварын материал, хүнсний материал, бусад хангамжийн материал, нөөцийн бараа материал 5.0-175.1 сая төгрөгөөр өссөн бол эм боох материал, мал амьтад 1.7-32.4 сая төгрөгөөр буурсан байна.

Тайлант онд нийт бараа материалын данс 7098.7 сая төгрөгөөр нэмэгдсэнээс төсвийн болон өөрийн хөрөнгөөр худалдаж авсан 6438.9 сая төгрөгийн, хандив тусламжаар 366.2 сая төгрөгийн, шилжүүлж авсан 98.7 сая төгрөгийн бараа материал байгаа бол бусад хэлбэрээр 194.8 сая төгрөгийн бараа материал нэмэгдсэн байна.

Тайлант онд нийт бараа материалын дүн 6523.1 сая төгрөгөөр буурснаас 6299.9 сая төгрөгийн бараа материалыг зарцуулсан буюу худалдсан, 27.4 сая төгрөгийн бараа материалыг шилжүүлсэн (зарим нь бүтцийн өөрчлөлтэй холбоотой), бусад байдлаар 195.8 сая төгрөгөөр бараа материалын данс буурсан байна.

8.2 ОНӨҮГ-ын бараа материал дансны талаар

ОНӨҮГ-ын бараа материалын жилийн эцсийн үлдэгдэл 398.0 сая төгрөг байгаагаас Онги-Ус суваг ОНӨҮГ 125.7 сая төгрөг буюу 31.6 хувь, Арвайхээр сумын Тохижилт үйлчилгээний ОНӨААТҮГ 82.0 сая төгрөг буюу 20.6 хувь, Хархорин-Ус суваг ХХК 16.5 сая төгрөг буюу 4.1 хувь, 18 сумын ЭЭСангууд 173.8 сая төгрөг буюу 43.7 хувийг тус тус эзэлж байна.

8.3 ОН-ын ТЕЗ-ийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар бараа материалтай холбоотой гарсан зөрчлийн талаар

Аудитаар бараа материалын үлдэгдлийг зөрүүтэй тайлагнасан, данс бүртгэлд орлого авалгүй шууд зардалд бүртгэсэн, бараа материалын хөдөлгөөний тайлан гаргаагүй, бараа материалыг анхан шатны баримтгүй зарцуулсан, тооллогод хамруулаагүй зэрэг **нийт 113.4 сая** төгрөгийн зөрчил илэрлээ. Үүнээс 14.4 сая төгрөгийн алдааг аудитаар залруулж, 99.0 сая төгрөгийн алдаа зөрчлийг залруулаагүй байна. Залруулагдаагүй алдаа зөрчлийн 75.0 сая төгрөгийн алдаа нь материаллаг бол 24.0 сая төгрөгийн алдаа зөрчил нь материаллаг бус байна. Тухайлбал,

- Хужирт сумын ЗДТГазар, Хархорин сумын Өрхийн эмнэлэг, Тарагт сумын Туяагийн бага сургууль зэрэг байгууллагуудад бараа материалыг тоолоогүй, тооцоо бодсон актаар баталгаажуулаагүй, нягтлан бодогч шалгаж үлдэгдэлтэйгээ тулгаж шалгаагүй, тооллогыг чанаргүй хийдэг зэрэг 57.8 сая төгрөгийн зөрчил илэрчээ.

- Бат-Өлзий сумын ИТХурал, аймгийн Музей, Хархорин сумын Өрхийн эмнэлэг, Баянгол сумын Соёлын төв, Уянга сумын ИТХурал, Баруунбаян-Улаан сумын цэцэрлэг, Соёлын төв, Арвайхээр сумын Нарны дөш өрхийн эмнэлэг, Бүрд, Өлзийт, Баян-Өндөр сумдын ЭЭСан, Богд сумын ЕБС, ЭМТөв, Тарагт сумын Туяагийн бага сургууль зэрэг байгууллагуудад бараа материалын тодотгол тайлангийн үлдэгдэл няравын тайлангаарх үлдэгдэл зөрүүтэй бүртгэгдсэн, эд хариуцагч тайлан дутуу гаргасан, эмийн эцсийн үлдэгдлийг жижиглэн худалдаалах үнээр тайлагнасан, зарцуулсан бараа материалыг үлдэгдлээр бүртгэсэн, дансны ангилал буруу сонгосон, бараа материалын үлдэгдэл дутсан зэрэг 22.6 сая төгрөгийн алдаа зөрчил илэрсэн байна.

- Аймгийн ЗДТГазар, БОАЖГазар, Хархорин сумын Спортын ордон, Нарийнтээл сумын ЗДТГазар, Гучин-Ус сумын ИТХурал, Уянга сумын Жаргалантын цэцэрлэг, Хужирт сумын 2-р цэцэрлэг, Арвайхээр сумын Уян сэтгэл өрхийн эмнэлэг, Тарагт сумын Туяагийн бага сургууль, Баян-Өндөр сумын ИТХурал, ЭЭСан, Есөнзүйл сумын цэцэрлэг, Богд сумын ЕБСургууль, ЭМТөв зэрэг байгууллагуудад анхан шатны баримтын бүрдэл дутуу,

хөрөнгийн зарцуулалтад бүртгэлээр тавих дотоод хяналтыг хэрэгжүүлээгүй зэрэг 21.1 сая төгрөгийн зөрчил илэрсэн.

- Уянга сумын ЗДТГазар, Соёлын төв, Жаргалантын эмнэлэг зэрэг байгууллагуудад бараа материалыг худалдан авч зарцуулахдаа материалын дансаар дамжуулж эд хариуцагчийн тайлан, тодотгол тайланд тусгалгүй шууд зардалд бүртгэсэн 11.9 сая төгрөгийн зөрчил илэрсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно”, 13.5 дахь “Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна гэсэн 13.7 дахь “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, 12 дугаар зүйлийн 12.2.1 дэх “жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг заавал хийнэ”, 14 дүгээр зүйлийн 14.4 дэх “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ”. 14.4.2 дахь “бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага бүртгэнэ”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70.2.-т “түүхий эд, материал, түлш, сэлбэг хэрэгсэл, бэлэн бүтээгдэхүүн, бараа, сав, баглаа боодлын тооллогыг жилд 2 удаа хийнэ” гэсэн заалт, 73.2-д “Байгууллагын нягтлан бодогч нь үндсэн хөрөнгө, бараа материал, үнэ бүхий зүйлийн тооллогоор бэлэн байсан үлдэгдэл, гарсан зөрүүг тооллогын акт материал батлагдсанаас хойш 5 хоногийн дотор нягтлан бодох бүртгэлд тусгаж дансны үлдэгдлийг тулган шалгана” гэсэн заалтуудыг тус тус зөрчиж байна.

Ес. Үндсэн хөрөнгийн талаар

9.1 Үндсэн хөрөнгийн бүтэц, бүрэлдэхүүн, тайлагналын талаар

Аймгийн ИТХТ-ийн 2016 оны 12 дугаар сарын 01-ны 03/06 тоот тогтоолоор авто замын сангийн хөрөнгө оруулалтын зардлыг 356.4 сая төгрөгөөр баталсан бол Аймгийн ИТХ-ын 2017 оны 05 дугаар сарын 08-ны 04/03 тоот тогтоолоор 73.6 сая төгрөгөөр нэмэгдүүлж 470,0 сая төгрөг болгон өөрчилсөн.

Аймгийн ИТХТ-ийн 2016 оны 12 дугаар сарын 01-ны 03/06 тоот тогтоолоор аймгийн төсвөөс сумын төсөвт олгох санхүүгийн дэмжлэгийг 4880.8 сая төгрөгөөр баталсан бол 2017 оны 11 дүгээр сарын 03-ны 05/01 тоот тогтоолоор 221.4 сая төгрөгөөр нэмэгдүүлж 5102.2 сая төгрөгөөр баталсан бол аймгийн орон нутгийн байгууллагын санхүүгийн дэмжлэгийг 2012.6 сая төгрөгөөр баталж, гүйцэтгэлээр 5115.4 сая төгрөгөөр санхүүжүүлсэн.

Аймгийн ИТХТ-ийн 2016 оны 12 дугаар сарын 01-ны 03/06 тоот тогтоолоор аймгийн ОНХСангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний зардлыг 1022.1 сая төгрөгөөр баталсан бол 2017 оны 11 дүгээр сарын 03-ны 05/01 тоот тогтоолоор 157.2 сая төгрөгөөр бууруулж 864.9 сая төгрөг болгон өөрчилсөн.

Аймгийн ИТХТ-ийн 2017 оны 05 дугаар сарын 08-ны 04/03 тоот тогтоолоор ОНТХО-аар хийгдэх төсөл, хөтөлбөр арга хэмжээний зардлыг 538.4 сая төгрөгөөр баталсан бол 2017 оны 11 дүгээр сарын 03-ны 05/01 тоот тогтоолоор 887.1 сая төгрөг болгон өөрчилсөн.

**ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН 2017 ОНЫ САНХҮҮГИЙН
НЭГТГЭСЭН ТАЙЛАНД ХИЙСЭН САНХҮҮГИЙН АУДИТ**

ОН-ын ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үндсэн хөрөнгө 2016 оны эцэст 220443.7 сая төгрөг байсан бол тайлант онд 5.6 хувь буюу 12753.4 сая төгрөгөөр нэмэгдэж 2017 оны эцэст 233197.1 сая төгрөгөөр тайлагнагдсан байна.

Үүнийг хүснэгтээр үзүүлбэл:

Хүснэгт 6
(сая.төг)

Ангилал	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Зөрүү дүн
Барилга байгууламж	146886.7	149659.5	2772.8
Тээврийн хэрэгсэл	6419.4	6976.8	557.4
Машин тоног төхөөрөмж	14652.7	20142.0	5489.3
Тавилга эд хогшил	5707.1	6249.9	542.8
Дуусаагүй барилга	4028.8	5469.2	1440.4
Зам, гүүрийн байгууламж	12135.1	13827.2	1692.1
Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	8455.3	8459.8	4.5
Бусад үндсэн хөрөнгө	20989.3	21206.4	217.1
Ном	891.8	928.7	36.9
Биет бус хөрөнгө	277.5	277.6	0.1
Дүн	220443.7	233197.1	12753.4

Нийт үндсэн хөрөнгийн 64.2 хувь нь барилга байгууламж байгаа нь өмнөх оноос 1.9 хувиар, 9.6 хувь нь бусад үндсэн хөрөнгө байгаа нь өмнөх оноос 1.0 хувиар, 8.6 хувь нь машин тоног төхөөрөмж байгаа нь өмнөх оноос 37.4 хувиар, 5.9 хувь нь зам гүүрийн барилга байгууламж байгаа нь өмнөх оноос 13.9 хувиар, 3.6 хувь нь түүх соёл, музейн дурсгалт зүйлс байгаа нь өмнөх оноос 0.1 хувиар, 3.0 хувь нь тээврийн хэрэгсэл байгаа нь өмнөх оноос 8.7 хувиар, 2.7 хувь нь тавилга, эд хогшил байгаа нь өмнөх оноос 9.5 хувиар, 2.3 хувь нь дуусаагүй барилга байгаа нь өмнөх оноос 35.7 хувиар, 0.4 хувь нь ном байгаа нь өмнөх оноос 4.1 хувиар тус тус өссөн байна.

Тайлант хугацаанд үндсэн хөрөнгө 14407.0 сая төгрөгөөр (үүний дотор худалдан авсан 1113.1, хандив тусламжаар 5121.2, шилжүүлж авсан 4421.3, бусад 6751.4) нэмэгдэж, 4653.5 сая төгрөгөөр (үүний дотор худалдсан 11.0 сая төгрөг, акталсан 1153.8 сая төгрөг, шилжүүлсэн 3487.6 сая төгрөг, бусад 1.1 сая төгрөг) хасагдаж, тайлант онд 9788.4 сая төгрөгийн элэгдэл байгуулсан байна.

9.2 ОН-ийн ТЕЗ-дын нэгтгэсэн санхүүгийн тайланд хийсэн аудитаар үндсэн хөрөнгөтэй холбоотой гарсан зөрчлүүдийн талаар

ОН-ийн ТЕЗахирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэгдсэн ТТЗ болон төсөвт байгууллага ОНӨААНэгжүүдийн тайланд хийсэн аудитаар үндсэн хөрөнгөтэй холбоотой нийт **1087.9 сая** төгрөгийн зөрчил илэрч 620.1 сая төгрөгийн алдаа зөрчлийг залруулж 467.8 сая төгрөгийн алдаа зөрчил залруулагдаагүй байна. Залруулагдаагүй нийт алдаанаас 44.0 сая төгрөгийн алдаа зөрчил нь материаллаг бол 423.8 сая төгрөгийн алдаа зөрчил нь материалаг бус алдаа байна. Үүнд:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6 "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах", 20.2.9 "аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага болон санхүүгийн тайлан хэрэглэгчдийг цаг хугацаанд нь үнэн, зөв мэдээллээр хангах ажлыг зохион

байгуулах, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 73.2-д “Байгууллагын нягтлан бодогч нь үндсэн хөрөнгө, бараа материал, үнэ бүхий зүйлийн тооллогоор бэлэн байсан үлдэгдэл, гарсан зөрүүг тооллогын акт материал батлагдсанаас хойш 5 хоногийн дотор нягтлан бодох бүртгэлд тусгаж дансны үлдэгдлийг тулган шалгана” заалтуудыг зөрчиж үндсэн хөрөнгийн тооллого, тооцоо бодолттой холбоотой 192.3 сая төгрөгийн зөрчил илэрсэн байна. Үүнд

- Гучин-Ус сумын Соёлын төв 10.3 сая төгрөг, Жаргалантын ЕБС 10.5 сая төгрөг, Есөнзүйл сумын Соёлын төв 8.1 сая төгрөгийн номыг тоолоогүй
- Уянга сумын ИТХ, Хужирт сумын ЗДТГ, БОАЖГазар, СХДААлба, Баянгол сумын ЕБС, Тарагт сумын ИТХ, МШУТөв зэрэг байгууллагууд 163.4 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн тооллогын баримт материалыг зөрүүтэй тайлагнасан, тооцоог бодож баталгаажуулаагүй байна.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.2 дах “Нягтлан бодох бүртгэлд бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлагыг заавал бүртгэнэ” гэсэн заалтыг зөрчиж, үндсэн хөрөнгийг санхүүгийн тайланд тусгаагүй, НББ-ийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1. “Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална”, 5.1.3 “жинхэнэ хэрэгжилтийн” 5.1.4. “үнэн зөв байх” гэсэн заалт, СС-ын 2006 оны 388 дугаар тушаал батлагдсан журам зөрчигдсөн нийт 410.2 сая төгрөгийн зөрчил илэрсэн байна

- Есөнзүйл сумын цэцэрлэг 2017 оны жилийн эцсийн тооллогоор 0.5 сая төгрөгийн хяналтын камерыг тоолж бүртгээгүй, бүртгэл тайланд тусгаагүй
- ГБХХТөв нь орон нутгийн төсвийн 9.9 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн Ёслолын танхимын шалны халаалт, мөн төсвийн 10.0 сая төгрөгөөр хийгдсэн дээврийн их засварыг ашиглалтанд хүлээн авсан боловч үндсэн хөрөнгийн бүртгэлд тусгаагүй байна.
 - ГБХХТөвийн санхүүгийн тайланд “Дөлгөөн хайрхан-Уул аудит ” компани аудит хийж 19.9 сая төгрөгөөр үндсэн хөрөнгө орлого авахуулж залруулга хийгдсэн боловч тайланг дутуу нэгтгүүлсэн байсныг залруулан бүртгэсэн.
 - Бат-Өлзий сумын Соёлын төвийн барилгын санхүүжилтэд орон нутгийн төсвөөс 2017 онд 579.9 сая төгрөгийг олгосон боловч гэрээний үнийн дүнгийн 949.9 сая төгрөгөөр орлого авч 369.9 сая төгрөгөөр илүү бүртгэсэн байсныг залруулан бүртгэсэн.

Хөрөнгийг зөв ангилан бүртгээгүй байгаа нь хөрөнгийн үнэ цэнийг бууруулах, элэгдэл тооцохгүй байх, ашиглалт хамгаалалтанд тавих дотоод хяналт алдагдах эрсдлийг бий болгож, УСНББОУС 17, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалын хавсралт 3-ын 4.78-ийн б-д “ Нэгээс дээш тайлангийн хугацаанд ашиглагдахаар хүлээгдэж байгаа хөрөнгийг үндсэн хөрөнгө гэнэ” гэсэн заалт, СС-ын 2012 оны 77 дугаар тушаалаар батлагдсан зааврын 2.9.1-д “Үндсэн хөрөнгийг шинж чанар, үйл ажиллагаанд ашиглагдах байдлаар нь ангилна” гэсэн заалтуудыг зөрчсөн нийт 54.3 сая төгрөгийн зөрчил дараах байгууллагуудад илэрсэн байна. Үүнд:

- ГБХХТөв 5.0 сая төгрөг, ББУлаан ЭМТөв 0.3 сая төгрөг, Есөнзүйлийн ЕБС 11.1 сая төгрөг, Богдын ЭМТөв 0.4 сая төгрөг, Мэргэд сургууль 37.5 сая төгрөгийн хөрөнгийг буруу ангилан бүртгэжээ.

УСНББОУСтандарт 17-гийн Үндсэн хөрөнгийн хүлээн зөвшөөрөлт хэсгийн 15-д “Үндсэн хөрөнгийн зүйл нь хүлээн зөвшөөрөлтийн эхний шалгуурыг хангаж буй эсэхийг тодорхойлохдоо байгууллага нь анхдагч хүлээн зөвшөөрөлтийн үед бэлэн буй нотлох зүйлд үндэслэн эдийн засгийн ирээдүйн өгөөж буюу үйлчилгээний чадавхийн тодорхой байдлын түвшинг үнэлэх шаардлагатай.” гэсэн заалт, санхүүгийн тайлангийн батламж мэдэгдлийн хүрээнд “Санхүүгийн тайлангийн дуусгавар болсон өдөр хөрөнгө,/авлага/ өр төлбөр тухайн аж ахуй нэгж байгууллагад бодитой оршин байх” гэсэн батламж мэдэгдлийг зөрчиж 39.2 сая төгрөгийн хөрөнгө биетээр оршин байхгүй байна. Үүнд:

- Гучин-Ус сумын ЗДТГазрын машин тоног төхөөрөмж дансанд бүртгэлтэй 34.2 сая төгрөгийн өртөг бүхий “Япон дизель”, бусад үндсэн хөрөнгө дансанд бүртгэлтэй 3.0 сая төгрөгийн өртөг бүхий “цагаан хаалганы гэрэлтүүлэг” хөрөнгө 2017 оны жилийн эцсийн хөрөнгийн тооллогоор бодитоор оршин байхгүй дутагдсан байна.
- Сант сумын Соёлын төв Лүн шавдаг ХХК-аас ном худалдан авахаар 1.0 сая төгрөг шилжүүлж, номыг нийлүүлээгүй байхад, үндсэн хөрөнгийн тайланд номыг нийт дүнгээр нь бүртгэлд авсан зөрчил гарсан.
- Хужирт сумын соёлын төв Лүн шавдаг ХХК-аас ном худалдан авахаар 1.0 сая төгрөг шилжүүлж номыг нийлүүлээгүй байхад үндсэн хөрөнгөд бүртгэсэн байна.

Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар батлагдсан “Нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”, 4.34 “Үндсэн хөрөнгийн засварын зардал нь үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг уртасгах гэх мэт уг хөрөнгөөс хүртэх эдийн засгийн өгөөжийг нэмэгдүүлж байвал уг зардлыг капиталжуулан үндсэн хөрөнгийн анхны өртгийг нэмэгдүүлнэ. Бусад тохиолдолд тайлант үеийн зардлаар хүлээн зөвшөөрнө”, НББОУС 16-д зааснаар “хөрөнгийн бодит үнэ цэнэ нэмэгдсэн байна.” гэсэн заалтуудыг зөрчиж Аймгийн музей 143.2 сая төгрөгийн засварын ажлыг үндсэн хөрөнгөндөө капиталжуулаагүй, тусад нь бүртгэсэн байна.

УСНББОУС 17, СС-ын 2006 оны 388 дугаар тушаалаар батлагдсан дансны зааврыг зөрчин санхүүгийн тайлангийн хэмжилт, тохируулга, тохиолдсон байх гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй 34.1 сая төгрөгийн зөрчил илэрсэн байна. Үүнд:

- Арвайхээр сумын ЦБСЦогцолбор нь “Хүүшийн гэгээ” ХХК-тай Арвайхээр сумын ЦБСЦ-ын биеийн тамирын заалны гадна, дотор дулаалга засварын 43.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажил гүйцэтгэх гэрээг 2017 оны 12 сарын 20-нд байгуулж, гэрээнд санхүүжилтийг гүйцэтгэлээс хамаарч төлбөрийг хэсэгчлэн төлнө гэж заасан боловч тус компанид гэрээ байгуулсан өдрөө санхүүжилтийн 78 хувь буюу 34.1 сая төгрөгийг шилжүүлж ажлыг гүйцэтгэж дуусаагүй, хүлээн аваагүй байхад барилга байгууламжийг капиталжуулж бүртгэсэн.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно” гэсэн заалтыг зөрчин үндсэн хөрөнгийн тайлан гаргаагүй, данснаас хассан болон шилжиж ирсэн хөрөнгийн шийдвэр болон анхан шатны баримтын бүрдүүлэлт дутуу зэрэг 63.0 сая төгрөгийн зөрчил Хужирт сумын ЭМТөв, ЗДТГазар, Арвайхээр сумын 6 дугаар цэцэрлэг зэрэг байгууллагуудад илэрсэн байна.

Санхүүгийн тайлангийн оршин байх, иж бүрэн байх, үнэлгээ, хэмжилт, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлийг зөрчиж үндсэн хөрөнгийн элэгдлийг зөрүүтэй тооцсон, хөрөнгийг орлого авахдаа эх үүсвэрийг буруу сонгосон, байдлын тайлан тодруулга тайлангийн хөрөнгийн дүн зөрүүтэй илэрхийлэгдсэн, хөрөнгө данснаас хасахтай

**ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН 2017 ОНЫ САНХҮҮГИЙН
НЭГТГЭСЭН ТАЙЛАНД ХИЙСЭН САНХҮҮГИЙН АУДИТ**

холбоотой дансны харьцааг буруу хийсэн, хуримтлагдсан элэгдэл дансны эхний үлдэгдэл буруу илэрхийлэгдсэн зэрэг санхүүгийн тайлангийн тооцоололтой холбоотой нийт 151.6 сая төгрөгийн зөрчил дараах байгууллагуудад илэрсэн. Үүнд:

- Тарагт, Есөнзүйл сумдын ЭЭСан, Уянга сумын ЗДТГазар, Соёлын төв, Сант сумын Цэцэрлэг, Хархорин сумын ЗДТГ, 3 дугаар цэцэрлэг, Музей, МШУТөв, Баянгол сумын ЕБСургууль

УСНББОУС 17, СС-ын 2006 оны 388 дугаар тушаалаар батлагдсан дансны зааврыг зөрчин санхүүгийн тайлангийн хэмжилт, тохируулга, тохиолдсон байх гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй 34.0 сая төгрөгийн зөрчил илэрсэн байна. Үүнд:

- Тарагт, Есөнзүйл сумдын ЭЭСан, Уянга сумын ЗДТГазар, Соёлын төв, Сант сумын Цэцэрлэг, Хархорин сумын ЗДТГ, 3 дугаар цэцэрлэг, Музей, МШУТөв, Баянгол сумын ЕБСургууль

Арав.Өр төлбөрийн бүртгэл, тайлагнал

10.1 Өр, төлбөрийн бүтцийн талаар

ОН-ийн ТЕЗ-ийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 554.6 сая төгрөг байснаас тайланд онд 212.6 сая төгрөгөөр буурч, оны эцэст 342.0 сая төгрөгт хүрсэн байна.

Нийт өр, төлбөрийн үлдэгдлийг бүтцээр харуулбал:

Хүснэгт 7
/сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Зөрүү
Ажилчидтай холбогдсон өглөг	6.1	14.2	8.1
Бараа үйлчилгээний зардлын өглөг	5.0	15.6	10.6
Байгууллагад төлөх өглөг	483.5	272.8	-210.7
Хувь хүмүүст төлөх өглөг	59.4	29.3	-30.1
Татварын өглөг /ТӨҮГ/	0.5	0.5	
НДШ-ийн өглөг /ТӨҮГ/	0.1	0.1	
Дансны өглөг /ТӨҮГ/		9.5	9.5
Нийт өглөг	554.6	342.0	-212.6

Тайлант хугацааны эцэст нийт өр төлбөрийн 79.7 хувийг байгууллагад төлөх өглөг, 8.5 хувийг хувь хүмүүст төлөх өглөг тус тус эзэлж байна. Байгууллагад төлөх өглөг өмнөх оноос 210.7 сая төгрөгөөр буурсан байна.

Өглөгийн үлдэгдлийг сум тус бүрээр задалж харуулбал:

Хүснэгт 8
/сая төгрөг/

Сумдын нэрс	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Зөрүү	Нийт дүнд эзлэх хувь
Баян-Өндөр	13.2	3.7	-9.5	-71.9
Бүрд	25.0	22.9	-2.1	-8.4
Бат-Өлзий	20.3	26.2	5.9	29.0

**ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН 2017 ОНЫ САНХҮҮГИЙН
НЭГТГЭСЭН ТАЙЛАНД ХИЙСЭН САНХҮҮГИЙН АУДИТ**

Баруунбаян-Улаан	54.3	36.6	-17.7	-32.6
Баянгол	6.3		-6.3	-100
Гучин-Ус	22.8	6.0	-16.8	-73.7
Есөнзүйл	2.1	5.6	3.5	166.7
Өлзийт	1.1	1.1		
Зүүнбаян-Улаан	9.4	1.8	-7.6	-80.8
Богд	9.9		-9.9	-100
Нарийнтээл	0.1		-0.1	-100
Сант	5.7	1.7	-4.0	-70.2
Тарагт	13.0	0.1	-12.0	-92.3
Төгрөг	3.9	0.1	-3.8	-97.4
Уянга	13.0	2.8	-10.2	-78.5
Хайрхандулаан	4.3	0.5	-3.8	-88.4
Хужирт	7.9		-7.9	-100
Хархорин	53.7	36.7	-17.0	31.6
Арвайхээр	50.7	50.7		
Аймгийн төв	237.6	145.5	-92.1	-38.7
Нийт	554.6	342.0	-212.6	-38.3

Хүснэгтээс үзэхэд тайлант оны эцэст нийт өр төлбөрийн 145.5 сая төгрөг буюу 42.5 хувь нь аймгийн төвийн байгууллагууд, 36.6 сая төгрөг буюу 10.7 хувь нь Баруунбаян-Улаан суманд, 36.7 сая төгрөг буюу 10.7 хувь нь Хархорин суманд, 50.7 сая төгрөг буюу 14.8 хувь нь Арвайхээр суманд ногдож байна.

Нийт өр төлбөрөөс Есөнзүйл, Бат-Өлзий сумын өр төлбөр 3.5-5.9 сая төгрөгөөр нэмэгдсэн бол бусад бүх сумдад 0.1-92.1 сая төгрөгөөр буурсан үзүүлэлттэй байна.

10.2 Өр, төлбөрийн дансны үлдэгдлийн баталгаажуулалтын талаар

ОН-ийн ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар өглөгийг буруу бүртгэсэн, бараа, ажил үйлчилгээг өглөгийн дансаар дамжуулалгүй шууд зардалд бүртгэсэн, өглөгийн үлдэгдлийг харилцагч байгууллага, иргэнтэй тооцоо нийлж актаар баталгаажуулаагүй зэрэг **нийт 16.6 сая** төгрөгийн алдаа зөрчил илэрч, аудитаар 13.4 сая төгрөгийн алдааг залруулсан байна. Залруулагдаагүй материаллаг 3.2 сая төгрөгийн зөрчлийг ангилбал:

- Баянгол сумын ЭЭСан, Бат-Өлзий сумын ЕБСургууль зэрэг байгууллагууд 3.2 сая төгрөгийн эм боох материал, НДШ-ийн тооцоогоор өглөгтэй гарсан байтал тооцоо нийлж үлдэгдлийг баталгаажуулаагүй байгаа нь НББ-ийн тухай хуулийн 20.2.6 дах "Байгууллагын нягтлан бодогч нь эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Арван нэг. Орлогын бүртгэл, тайлагнал

11.1 ОН-ийн санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлангийн талаар

**ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН 2017 ОНЫ САНХҮҮГИЙН
НЭГТГЭСЭН ТАЙЛАНД ХИЙСЭН САНХҮҮГИЙН АУДИТ**

2017 оны ОН-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үр дүнгийн тайлангаарх үйл ажиллагааны орлогын нийт дүн 123571.5 сая төгрөг бөгөөд өмнөх онтой харьцуулахад 3246.3 сая төгрөгөөр буурсан байна. (Хавсралт 1)

Хүснэгт 9

Үзүүлэлт	/сая төгрөг/		
	Өмнөх он	Тайлант он	Зөрүү
Татварын орлого	9093.4	10120.7	1027.3
Татварын бус орлого	367.0	1122.0	755.0
Төсөвт байгууллагын өөрийн орлого	3975.0	3099.1	-875.9
Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	22074.3	14379.6	-7694.7
Улсын төсвөөс орон нутгийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэг	12574.6	12415.7	-158.9
Тусламж санхүүжилтийн орлого	78733.5	82434.4	3700.9
Нийт дүн	126817.8	123571.5	-3246.3

Дээрх хүснэгтээс харахад татварын орлого 1027.3 сая төгрөг буюу 11.2 хувиар татварын бус орлого 755.0 сая төгрөг буюу 205.7 хувиар, тусламж санхүүжилтийн орлого 3700.9 сая төгрөг буюу 4.7 хувиар тус тус өссөн байна. Улсын төсвөөс орон нутгийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэг өмнөх оноос 158.9 сая төгрөгөөр буюу 1.2 хувиар, төсөвт байгууллагын өөрийн орлого 875.9 сая төгрөгөөр буюу 22.0 хувиар, үнэ төлбөргүй хүлээн авсан орлого 7694.7 сая төгрөгөөр буюу 34.8 хувиар тус тус буурсан байна.

ОН-ийн санхүүгийн байдлын нэгтгэсэн тайлангийн тайлант үеийн үр дүн 5083.1 сая төгрөгөөр тайлагнагдсан байна.

11.2 Мөнгөн гүйлгээний тайлангийн болон төсвийн гүйцэтгэлийн орлогын талаар

11.2.1 Татварын болон татварын бус орлогын талаар

Аймгийн ИТХТ-ийн 2016 оны 12 дугаар сарын 01-ны 03/06 тоот тогтоолоор аймгийн төсөвт төвлөрүүлэх татварын орлогыг 7709.3, татварын бус орлогыг 318.3, нийт орлогыг 8027.6 сая төгрөгөөр баталж, 2017 оны 05 дугаар сарын 08-ны 04/03 тоот тогтоолоор бусад татварын орлогыг 112.0 сая төгрөгөөр, 2017 оны 11 дүгээр сарын 03-ны 05/01 тоот тогтоолоор Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 8.1.1-д заасан орлогод ногдох албан татварын орлогоос хадагламжийн хүүгийн орлогыг 730.0 сая төгрөгөөр, авто тээвэр болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын орлогыг 11.0 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлснээр татварын 8450.3, татварын бус 430.3, нийт орлого 8880.6 сая төгрөгөөр батлагдсан байна.

Аймгийн ИТХТ-ийн 2016 оны 12 дугаар сарын 01-ны 03/06 тоот тогтоолоор хувь хүний орлогын албан татварын буцаан олголтыг 700.0 сая төгрөгөөр баталсан бол 2017 оны 11 дүгээр сарын 03-ны 05/01 тоот тогтоолоор 242.2 сая төгрөгөөр нэмж 942.2 сая төгрөг олгохоор баталжээ.

Аймгийн ИТХТ-ийн 2016 оны 12 дугаар сарын 01-ны 03/06 тоот тогтоолоор аймгийн 2017 оны төсөвт төсвийн ерөнхийлөн захирагч, түүний харъяа байгууллага, бусад байгууллагын төвлөрүүлэх орлогын хэмжээг 224.8 сая төгрөгөөр баталж, 2017 оны 11 дүгээр сарын 03-ны 05/01 тоот тогтоолоор орон нутгийн өмчийн газрын өөрийн орлогыг

**ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН 2017 ОНЫ САНХҮҮГИЙН
НЭГТГЭСЭН ТАЙЛАНД ХИЙСЭН САНХҮҮГИЙН АУДИТ**

4.9 сая төгрөгөөр нэмэгдүүлж төвлөрүүлэх өөрийн орлогыг 229.7 сая төгрөгөөр өөрчилөн баталжээ.

2017 оны ОН-ийн татварын орлого 11189.8 сая төгрөгөөр төлөвлөгдсөн боловч 12164.5 сая төгрөгийн буюу 108.7 хувийн биелэлттэй 974.7 сая төгрөгөөр ОН-ийн төсвийн орлого давж биелсэн.

ОН-ын татварын орлогын төлөвлөгөөний биелэлт

Хүснэгт 10
Сая төгрөгөөр

	Нийт орлого	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	биелэлт
1	Аймгийн төсөвт төвлөрүүлэх орлого	8880.6	9221.8	103.8
2	Сумын төсөвт төвлөрүүлэх орлого	2309.2	2942.8	127.4
	Нийт дүн	11189.8	12164.5	108.7

Аймгийн төсөвт орох татварын орлогоор 8880.6 сая төгрөгөөр төлөвлөж гүйцэтгэлээр 9221.8 сая төгрөг оруулж орлогын төлөвлөгөөний биелэлт 103.8 хувийн биелэлттэй.

Сумын төсөвт орох татварын орлогоор 2309.2 сая төгрөг оруулахаас гүйцэтгэлээр 2942.8 сая төгрөг оруулж 127.4 хувийн биелэлттэй байна.

Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт 942.2 сая төгрөг байна. Үүнийг хасч тооцвол аймгийн дүнгээр 11222.3 сая төгрөгийн татварын орлого төвлөрчээ.

1. Аймгийн 2017 оны төсвийн орлогын төлөвлөгөөний биелэлт Хүснэгт 11
/сая төгрөгөөр/

д/д	Орлогын нэр төрөл	Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	Биелэлт хувиар
1	Аймгийн төсвийн орлого бүгд	8880.6	9221.7	103.8
2	Аймгийн төсвийн татварын орлого	8450.3	8513.7	100.7
2.1	Газрын төлбөр	125.0	109.1	87.3
2.2	Үл хөдлөх хөрөнгийн албан татвар	290.0	328.9	113.4
2.3	Авто тээвэр өөрөө явагч хэрэгслийн албан татвар	481.0	512.8	106.6
2.4	Үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар ашигласан усны төлбөр	305.7	438.8	143.5
2.5	Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 8.1.1-д заасан орлогод ногдох албан татвар	7135.9	6991.6	98.0
2.6	Улсын тэмдэгтийн хураамж	112.7	132.5	117.5
3	Аймгийн төсвийн татварын бус орлого	430.3	708.0	164.5
3.1	Хүү, торгуулийн орлого	83.3	647.3	564.0
3.2	Бусад орлого	312.0	44.7	-267.3
3.3	Орон нутгийн өмчийн оролцоотой Баянтээг ХК-ны ногдол ашиг	35.0	16.0	-19.0

Аймагт төвлөрүүлэх татварын орлогоос газрын төлбөрийн орлого 12.7, хувь хүний орлогын албан татварын орлогын төлөвлөгөө 2 хувиар биелэгдээгүй бол бусад орлогууд давж биелсэн байна.

2. Сумын татварын орлогын төлөвлөгөөний биелэлт

Хүснэгт 12
/сая төгрөгөөр/

д/д	Орлогын нэр төрөл	Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	Биелэлт хувиар
1	Сумын татварын орлогын дүн	2309.2	2942.8	127.4
1.1	Үйл ажиллагааны орлого /Аж ахуй эрхэлсний орлого	567.5	654.9	115.4
1.2	Хөрөнгө борлуулсны орлого	82.6	83.6	101.2
1.3	Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч иргэний орлогын албан татвар	73.2	108.8	148.6
1.4	Улсын тэмдэгтийн хураамж	110.4	119.4	108.1
1.5	Бууны албан татвар	58.8	45.2	76.9
1.6	Түгээмэл дархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	47.4	34.2	72.1
1.7	Хог хаягдлын үйлчилгээний хураамж	498.7	493.5	98.9
1.8	Ургамал ашигласны төлбөр			
1.9	Ойн нөөц ашигласны төлбөр	237.8	606.8	255.2
1.10	Ан амьтны нөөц ашигласны төлбөр	260.8	269.5	103.3
1.11	Ус ашигласны төлбөр	5.0	7.3	146
1.12	Бусад татвар	2.4	83.7	3487.5
1.13	Нохойн татвар	8.5	2.6	30.5
1.14	Торгуулийн орлого	356.1	433.3	121.7

Суманд төвлөрүүлэх татварын орлогоос бууны албан татвар 23.1 хувиар, түгээмэл дархацтай ашигт малтмал ашигласны төлбөр 27.9 хувиар, хог хаягдлын үйлчилгээний хураамж 1.1 хувь, нохойн татварын орлогын төлөвлөгөө 69.5 хувиар тус тус биелэгдээгүй байна.

11.4.2 Тусламж, санхүүжилтийн орлогын талаар

Аймгийн ИТХТ-ийн 2016 оны 12 дугаар сарын 01-ны 03/06 тоот тогтоолоор Улсын төсвөөс авах санхүүгийн дэмжлэгийг 11418.4 сая төгрөгөөр баталж, Монгол улсын 2017 оны төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийг үндэслэн Аймгийн ИТХ-ын 2017 оны 05 дугаар сарын 08-ны 04/03 тоот тогтоолоор 3.0 сая төгрөгөөр бууруулж, 2017 оны 11 дүгээр сарын 03-ны 05/01 тоот тогтоолоор 1000.3 сая төгрөгөөр нэмэгдүүлж 12415.7 сая төгрөгөөр өөрчлөн баталсан. Гүйцэтгэлээр бүрэн санхүүжигдсэн байна.

Аймгийн ИТХТ-ийн 2016 оны 12 дугаар сарын 01-ны 03/06 тоот тогтоолоор Аймгийн төсвөөс 2017 оны төсвийн жилд сумдад олгох Засгийн газрын чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх тусгай зориулалтын шилжүүлгийн хэмжээг 44769.7 сая төгрөгөөр баталж, Аймгийн ИТХТ-ийн 2017 оны 05 дугаар сарын 08-ны 04/03 тоот тогтоолоор 590.3 сая төгрөгөөр бууруулж 44179.4 сая төгрөг болгон өөрчилсөн бол 2017 оны 11 дүгээр сарын 03-ны 05/01 тоот тогтоолоор 1060.5 сая төгрөгөөр нэмэгдүүлж 45239.9 сая төгрөг болгон өөрчилсөн. Гүйцэтгэлээр 45470.9 сая төгрөгийн санхүүжилт авсанаар тайлагнажээ.

Аймгийн ИТХТ-ийн 2016 оны 12 дугаар сарын 01-ны 03/06 тоот тогтоолоор аймгийн ОНХСангаас сумын ОНХСанд олгох орлогын шилжүүлгийг 2132.2 сая төгрөгөөр баталж Аймгийн ИТХТ-ийн 2017 оны 05 дугаар сарын 08-ны 04/03 тоот тогтоолоор 121.7 сая

төгрөгөөр нэмэгдүүлж 2253.9 сая төгрөг болгон өөрчилөн баталсан. Гүйцэтгэлээр бүрэн санхүүжигдсэн байна.

11.5. ОН-ын ТЕЗ-ийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар орлоготой холбоотой гарсан зөрчлийн талаар

Хөрөнгийн орлого дутуу тусгасан, данс буруу сонгосон, орлого үр дүнгийн тайланг буруу илэрхийлсэн зэрэг **466.6 сая төгрөгийн** зөрчил илэрсэн байна. Үүний 461.4 сая төгрөгийн зөрчлийг аудитаар залруулж, 5.2 сая төгрөгийн материаллаг бус зөрчлийг залруулаагүй зөвлөмж өгсөн байна. Илэрсэн зөрчлүүдийг ангилбал:

- Есөнзүйл сумын ЕБСургууль 4.3 сая төгрөгийн хөрөнгийн орлогыг дутуу тусгасан зөрчил илэрсэн байна.
- Хайрхандулаан сумын цэцэрлэг, Нарийнтээл сумын ЕБСургууль, Гучин-Ус сумын ЗДТГазар, Баруунбаян-Улаан сумын Төрийн сан, Богд сумын цэцэрлэг, Хужирт сумын ЭМТөв, Арвайхээр сумын 5-р цэцэрлэг, ЕБ-ийн 4-р сургууль зэрэг байгууллагууд нийт 398.3 сая төгрөгийн хөрөнгийг бүртгэхдээ орлогын данс буруу сонгосон байна.
- Есөнзүйл сумын ЭЭСан, Баянгол сумын ЭЭСан, Баян-Өндөр сумын СХСан, ЭЭСан, Бүрд сумын ЭЭСан, Өлзийт сумын ИТХурал, Уянга сумын СХСан, Зүүнбаян-Улаан сумын СХСан, Хархорин сумын ЗДТГазар, Баруунбаян-Улаан сумын СХСан зэрэг байгууллагуудад нийт 64.0 сая төгрөгийн орлого үр дүнгийн тайланг буруу илэрхийлсэн зөрчил илэрсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.5 "бүх орлогыг нягтлан бодох бүртгэлд заавал бүртгэнэ" заалт, СС-ын 2006 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн 388 дугаар тушаалаар батлагдсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар", СС-ын 2012 оны 77 тоот тушаалаар батлагдсан "Аж ахуйн нэгжийн Санхүүгийн тайлан тодруулгыг бэлтгэх зааврын 3-д Орлогын дэлгэрэнгүй тайланд орлогыг хүлээн авсан эсхүл авахаар хүлээгдэж буй төлбөрийн бодит үнэ цэнээр хэмжинэ. Орлоготой холбогдож гарсан борлуулалтын өртөг болон бусад зардлыг жинхэнэ гарсан хэмжээгээр нь тусгана" заалтуудыг тус тус зөрчиж байна.

Арван хоёр. Зардлын бүртгэл, тайлагнал

12.1 Зардлын бүтцийн талаар

Аймгийн ИТХТ-ийн 2016 оны 12 дугаар сарын 01-ны 03/06 тоот тогтоолоор аймгийн 2017 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагч, тэдгээрийн харъяа байгууллагуудын төсвийн зарлагыг 14030.0 сая төгрөгөөр баталж 2 удаа тодотгож 14154.6 сая төгрөг болгон өөрчилсөн.

Өвөлжилтийн бэлтгэл хангахтай холбогдуулан өвс, тэжээлийн аюулгүйн нөөц бүрдүүлэхэд 423.4 сая төгрөгийг орон нутгийн төсвийн нөөц хөрөнгийн зардлаас тайлант онд 275.7 сая төгрөг зарцуулсан.

Тайлант оны ОН-ийн ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үр дүнгийн тайланд нийт зардал 117066.8 сая төгрөгийн зарцуулалттай тайлагнагдсан нь өмнөх оноос 7061.1 сая төгрөгөөр өссөн байна.

**ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН 2017 ОНЫ САНХҮҮГИЙН
НЭГТГЭСЭН ТАЙЛАНД ХИЙСЭН САНХҮҮГИЙН АУДИТ**

ОН-ийн ТЕЗ-ийн 2017 оны нийт зарцуулалтыг ОН-ийн үр дүнгийн нэгтгэсэн тайланд тайлагнасны дагуу нийт зардлыг эдийн засгийн ангиллаар тайлант оны зардлын эзлэх хувийг хүснэгт №13, сумдын нийт зардлыг хүснэгт №14 харуулав.

Нийт зардлыг бүтцээр нь харуулбал:

Хүснэгт 13
/сая төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН	ЭЗЛЭХ ХУВЬ
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	110005.7	117066.8	100
УРСГАЛ ЗАРДАЛ	104341.9	113216.4	96.7
БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	61929.2	66419.3	58.7
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	33088.7	34134.7	51.4
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	3672.0	3767.3	5.7
Байр ашиглалттай холбоотой тогтмол	5217.4	5550.0	8.4
Хангамж, бараа материалын зардал	1861.2	1730.6	2.6
Нормативт зардал	3085.2	3287.9	4.9
Эд хогшил, урсгал засварын зардал	618.9	841.6	1.3
Томилолт, зочны зардал	286.8	263.2	0.4
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, Бараа үйлчилгээний бусад зардал	2586.0	3167.3	4.8
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	11512.8	13676.7	20.6
ХҮҮ	5663.8	3850.3	3.3
ТАТААС	30.6	13.1	
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	57.0	56.1	
	42325.1	46728.0	41.3

Нийт зардлын 96.7 хувийг урсгал зардал эзэлж байгаа бол 3.3 хувийг хөрөнгийн зардал эзэлж байна. Урсгал зардал өмнөх оноос 8874.5 сая төгрөгөөр өссөн бол хөрөнгийн зардал 1813.5 сая төгрөгөөр буурсан байна.

Урсгал зардлын 58.7 хувийг бараа үйлчилгээний зардал эзэлж байгаа бол 41.3 хувийг урсгал шилжүүлэг эзэлж байна.

Нийт зардлыг сумдаар үзүүлвэл:

Хүснэгт 14
(сая төгрөгөөр)

СУМДУУД	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН	ЗӨРҮҮ
Баян-Өндөр	2383.0	2381.8	-1.2
Бүрд	2052.7	2120.7	68.0
Бат-Өлзий	4305.9	4798.0	492.1
Баруунбаян-Улаан	2298.0	2260.0	-38.0
Баянгол	2,391.6	2435.1	43.5
Гучин-Ус	2,236.2	2209.0	-27.2
Есөнзүйл	1778.6	1724.7	-53.9
Өлзийт	1851.3	1762.6	-88.7
Зүүнбаян-Улаан	2,216.2	2200.5	-15.7
Богд	3187.7	3349.8	162.1

**ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН 2017 ОНЫ САНХҮҮГИЙН
НЭГТГЭСЭН ТАЙЛАНД ХИЙСЭН САНХҮҮГИЙН АУДИТ**

Нарийнтээл	2680.6	2893.3	212.7
Сант	2,294.9	2493.2	198.3
Тарагт	2097.5	2088.5	-9.0
Төгрөг	2267.9	2314.6	46.7
Уянга	4568.5	4830.8	262.3
Хайрхандулаан	2240.1	2384.5	144.4
Хужирт	3791.4	4296.2	504.8
Хархорин	6618.7	7212.4	593.7
Арвайхээр	15060.4	17152.1	2091.7
Аймгийн төв	43684.5	46178.6	2494.1
Бүгд	110005.7	117066.8	7061.1

Бүрд, Бат-Өлзий, , Баянгол, Богд, Сант, Нарийнтээл, Төгрөг, Уянга, Хайрхандулаан, Хужирт, Хархорин, Арвайхээр сумдууд, аймгийн төвийн байгууллагуудад төсвийн зарлага 43.5-2494.1 сая төгрөгөөр өссөн бол Гучин-Ус, Өлзийт, Баруунбаян-Улаан, Баян-Өндөр, Есөнзүйл, Зүүнбаян-Улаан, Тарагт зэрэг сумдуудад 1.2-88.7 сая төгрөгөөр буурсан байна.

12.2 Төсвийн гүйцэтгэлийн талаар

Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагч нь нэгтгэсэн төсвийн зарлагыг 76979.8 сая төгрөгөөр баталж, гүйцэтгэлээр 73993.5 сая төгрөг зарцуулж, 2986.3 сая төгрөгийн хэмнэлттэй гарчээ.

ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

Хүснэгт 15
(сая төгрөгөөр)

Төсвийн зарлага	Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	Зөрүү	Нийт зардалд эзлэх хувь
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	32968.5	32775.6	-192.9	42.3
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	3635.3	3605.8	-29.5	4.9
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	5459.4	5427.4	-32.0	7.3
Хангамж, бараа материалын зардал	1306.6	1293.0	-13.6	1.7
Нормативт зардал	3310.5	3282.6	-27.9	4.4
Эд хогшил, урсгал засварын зардал	970.7	960.3	-10.4	1.3
Томилолт, зочны зардал	235.3	230.2	-5.1	0.3
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1721.4	1512.3	-209.1	2.0
Бараа үйлчилгээний бусад зардал	2695.1	2790.8	95.7	3.8
Татаас	116.1	116.1		0.1
Урсгал шилжүүлэг	16090.3	15672.9	-417.4	21.2
Хөрөнгийн зардал	4367.1	4177.6	-189.5	5.6
Эргэн төлөгдөх зээл	4102.3	2148.7	-1953.6	2.9
Нийт зардлын дүн	76979.8	73993.5	-2986.3	100

Нийт төсвийн зарлагын 47.2 хувь нь ажиллагсадтай холбогдсон зардал, 21.2 хувийг урсгал шилжүүлэг, 5.6 хувийг хөрөнгийн зардал, 7.3 хувийг байр ашиглалттай холбоотой тогтмол зардал, 4.4 хувийг нормативт зардал, 3.8 хувийг бараа үйлчилгээний

бусад зардал, 2.9 хувийг эргэн төлөгдөх зээл, 2.0 хувийг бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, хураамж, 0,1-1.7 хувийг бусад зардал эзэлж байна.

Батлагдсан төсөвтэй зэрэгцүүлэн үзэхэд 2986.3 сая төгрөгөөр төсөв хэмнэгдсэн байна. Үүнийг зардлын нэр төрлөөр авч үзвэл бараа үйлчилгээний бусад зардлаас бусад зардлууд хэмнэгдсэн байна.

12.3 ОН-ийн ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар зардалтай холбоотой гарсан зөрчлүүдийн талаар

ОН-ийн ТЕЗ-ийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар зардлын данстай холбоотой нягтлан бодох бүртгэлийн холбогдох стандарт, журам, заавар мөрдөөгүй, дансны бичилт буруу хийсэн, төсвийг зориулалт бусаар зарцуулсан, бүрдүүлбэр дутуу анхан шатны баримтаар зарцуулалт хийсэн зэрэг нийт **239.3 сая** төгрөгийн алдаа, зөрчлүүдээс 98.8 сая төгрөгийн алдаа зөрчлийг залруулж 140.5 сая төгрөгийн алдаа зөрчил залруулагдаагүй байна. Залруулах боломжгүй нийт алдаанаас 81.9 сая төгрөгийн алдаа зөрчил нь материаллаг бол 58.6 сая төгрөгийн алдаа зөрчил нь материаллаг бус байна.

Илэрсэн зөрчлийг зардлын зүйл ангиар авч үзэхэд дараах байдалтай байна. Цалин хөлс болон нийгмийн даатгалын шимтгэлийн зардалд 140.8 сая төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардалд 3.1 сая төгрөг, хангамж бараа материалын зардалд 30.2 сая төгрөг, нормативт зардалд 2.4 сая төгрөг, эд хогшил урсгал засварын зардалд 7.7 сая төгрөг, томилолт зочны зардалд 0.4 сая төгрөг, бусад зардалд 54.7 сая төгрөгийн зөрчил тус тус илэрсэн байна.

12.3.1 Бараа үйлчилгээний зардалтай холбоотой гарсан зөрчлүүдийн талаар

Цалин хөлс, НДШ, хангамж бараа материал, томилолт зочны болон нормативт зардал, эд хогшил урсгал засварын зардлуудыг Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 6 дугаар зүйлийн 6.4.8-д “Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, 6 дугаар зүйлийн 16.5.5-д “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” 41.2.2 дах “ Батлагдсан төсвийн хүрээнд зардал гаргах” гэсэн заалтууд, НББ-ийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккрузал сууриар хөтөлнө" , 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.", 14.4.1-д “аж ахуйн бүх ажил, гүйлгээг заавал бүртгэнэ” гэсэн заалт 14.4.6 –д “Нягтлан бодох бүртгэлд тайлант онд гарсан бүх зардлыг заавал бүртгэнэ” гэсэн заалтуудыг зөрчин хөрөнгийг зарцуулсан байна.

Мөн 2017 оны төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хууль батлагдсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай УИХ-ын 2017 оны 29 дүгээр тогтоолын Төсвийн урсгал зардлын талаар авах арга хэмжээний 1.1.в-д " 2017 оны 5 дугаар сарын 1-ээс 2018 оны 12 дугаар сарын 31 хүртэл хугацаанд зөвхөн эрүүл мэнд, боловсролын үйлчилгээ буюу төрийн өмчийн бүх шатны сургууль эмнэлэг цэцэрлэгийн байгууллагаас өндөр насны тэтгэвэрт гарах 2 албан хаагч тутамд 1 албан хаагчийг нөхөн томилох ба үүнд эрүүл мэнд, боловсролын салбарын захиргааны байгууллагыг хамааруулахгүй байх", 1.1.б-д "Төрийн албан хаагчийн албан тушаалын зэрэглэл, шатлалыг ахиулахыг түр зогсоож, энэ талаар шийдвэр гаргахгүй байхыг бүх шатны төсвийн ззахирагч нарт даалгах" гэсэн заалт, 1.2.е-д “төсвийн хөрөнгөөр шууд болон шууд

бус хэлбэрээр жинэ жил, баяр ёслолын аливаа арга хэмжээг зохион байгуулах, цаасан мэндчилгээ илгээх, баяр ёслол, ой тэмдэглэх зорилгоор бэлэг дурсгалын зүйлс, цүнх, календарь зэрэг зүйлс бэлтгэх, ивээн тэтгэхийг хориглох” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Бараа үйлчилгээний зардалтай холбоотой нийт 184.6 сая төгрөгийн зөрчил илэрсэн. Тухайлбал:

1.Цалин НДШ-ийн зардалтай холбоотой 140.8 сая төгрөгийн дараах зөрчлүүд илэрчээ.

- Хархорин, Сант сумдын ИТХ, Баруунбаян-Улаан сумын цэцэрлэг, Богдын ЭМТөв, Хужиртын соёлын төв, Арвайхээр сумын ИТХ, Баянгол, Нарийнтээл сумдын ЕБС зэрэг байгууллагууд 10.1 сая төгрөгийн цалин, шимтгэлийг илүү тооцож олгосон байна.
- Сант сумын ИТХ, Гучин-Ус сумын Соёлын төв, Бүрд, Нарийнтээл, ББУлаан сумдын цэцэрлэг, Арвайхээр сумын 1, 5-р цэцэрлэг, 4 дүгээр сургууль, Жаргалантын ЭМТөв зэрэг байгууллагуудад 22.0 сая төгрөгийн цалин, НДШ-тэй холбоотой зардлыг тайланд илүү болон дутуу тусгасан байна.
- Сант сумын Соёлын төв, ЕБС, Есөнзүйл сумын ИТХ, Өлзийт, Баянгол, Хайрхандулаан сумдын Соёлын төв, Хорхорин сумын Спортын ордон зэрэг байгууллагууд цалингийн зардлаас 8.8 сая төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан байна.
- Бат-Өлзий сумын ЕБС, Уянгын жаргалантын ЕБС, Хархорины 3 дугаар цэцэрлэг, Арвайхээр, Баян-Өндөр сумдын ИТХ, Бүрд сумын ЭМТөв, Соёлын төв, Баянгол сумын Соёлын төв зэрэг байгууллагууд УИХ-ын 29 дүгээр тогтоолыг зөрчин 10.7 сая төгрөгийн цалингийн зардлыг хэмнээгүй байна.
- Бүрд сумын ЭМТөв нь Төсвийн тухай хуулийн 16.5.3-т заасныг зөрчин батлагдсан орон тоог хэтрүүлэн 1 хүнийг жилийн турш ажиллуулснаар 5.6 сая төгрөгийг зарцуулсан.
- НББ-ийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно”, 13 дугаар зүйлийн 13.5 дах “Анхан шатны баримтанд түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу, шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно”, 13.7 дах “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэсэн заалтуудыг зөрчиж 3 байгууллага 83.6 сая төгрөгийн зардлыг анхан шатны баримт дутуу болон баримтгүйгээр зарцуулсан байна.

2.Тогтмол зардалтай холбоотой 3.1 сая төгрөгийн дараах зөрчил илэрсэн.

- Богд сумын ЭМТөв, Есөнзүйл сумын цэцэрлэг, Нарийнтээл, Төгрөг сумдын Соёлын төв зэрэг байгууллагууд 0.7 сая төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан.
- НББ-ийн тухай хуулийн 13.5 дах заалт болон Сангийн сайдын 388 дугаар тушаалыг зөрчин Богд сумын соёлын төв, Хужиртын 2-р цэцэрлэг, Хайрхандулаан сумын цэцэрлэг зэрэг байгууллагууд 2.4 сая төгрөгийн зардлыг анхан шатны баримт дутуу болон баримтгүйгээр зарцуулсан байна.

3.Нормативт зардалтай холбоотой 2.4 сая төгрөгийн дараах зөрчил илэрсэн.

- Хархорин сумын Спортын ордон, ББУлаан сумын Соёлын төв, Бүрд сумын ЭМТөв, зэрэг байгууллагууд 1.2 сая төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан.
- Есөнзүйл сумын ЕБС нь "Шилмэл сүрэг" хоршооноос 5 үхэр, 85 хонь, 3 адууг 11.2 сая төгрөгөөр худалдан авсан ба малаа нядлаад махаа орлого авахдаа үхэр адууны мах нь авсан үнээ барихгүй 0.8 сая төгрөгөөр дутагдаж, байгууллагыг хохироосон байна.
- Тус байгууллага нь хавар тариалах 0.4 сая төгрөгийн үрийн төмсөө эргэлтийн хөрөнгөнд бүртгэлгүй шууд зардалд бичилт хийсэн.

4. Хангамж бараа материалын зардалтай холбоотой 30.2 сая төгрөгийн дараах зөрчил илэрсэн.

- Жаргалантын цэцэрлэг, ЗБУлаан, Өлзийт, Арвайхээр сумдын ИТХ, Баян-Өндөр, сумдын Соёлын төв, Цэцэрлэг зэрэг байгууллагууд 0.7 сая төгрөгийн хангамж бараа материалын зардлыг зориулалт бусаар зарцуулсан байна.
- ЗБУлаан сумын цэцэрлэг, Есөнзүйл сумын ИТХ, Арвайхээр сумын ТҮК, Богд, Хайрхандулаан, Бүрд сумдын ЭЭСан, Төгрөг сумын Соёлын төв зэрэг байгууллагууд нь 25.3 сая төгрөгийг анхан шатны бүрдүүлбэр дутуу баримтаар зарцуулсан зөрчил гаргасан.
- ББУлаан сумын ЗДТГ, Сум хөржүүлэх сан нь 4.2 сая төгрөгийн зардлыг буруу бүртгэсэн байна.

5. Томилолтын зардалтай холбоотой илэрсэн 0.4 сая төгрөгийн зөрчил нь анхан шатны баримтын бүрдүүлэлтийг хангаагүй байна.

6. Уянга сумын ЭМТөв нь Эрч хүч ХХК-аар 7.7 сая төгрөгийн барилга засварын ажил хийлгэсэн боловч ажлын гэрээ байгуулаагүй, засварын ажлыг актаар хүлээн аваагүй байна.

12.3.2 Бараа үйлчилгээний бусад зардалтай холбоотой зөрчлүүдийн талаар

Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д "Санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", 6 дүгээр зүйлийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", 41 дүгээр зүйлийн 41.2.2-д "Батлагдсан төсвийн хүрээнд зардал гаргах" гэсэн заалтууд, НББ-ийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.2-т "Бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлагыг нягтлан бодох бүртгэлд заавал бүртгэнэ", 20 дугаар зүйлийн 2.6-д "Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэсэн заалтууд болон УИХ-ын 2017 оны 67 дугаар тогтоолын 1.1 дэх заалт "2017 оны төсвийн жилд төрийн өндөр албан тушаалтан, шүүгч, прокуроороос бусад төрийн албан хаагчид 300.0 мянган төгрөгийн ажлын үр дүнгийн урамшуулал олгох, МУЗГ-ын 2017 оны 12 дугаар сарын 06- ны өдрийн хуралдааны тэмдэглэлээр 300.0 мянган төгрөгийн урамшууллыг сахилгын шийтгэл хүлээсэн бөгөөд сахилгын шийтгэлгүйд тооцох хугацаа нь дуусаагүй байгаа албан хаагчаас бусад төрийн албан хаагчдад мөнгөн урамшуулал олгох арга хэмжээ авахаар шийдвэрлэснийг" гэсэн заалт, УИХ-ын 2017 оны 29 дүгээр тогтоолын Төсвийн урсгал зардлын талаар авах арга хэмжээний 1.2.е-д "төсвийн хөрөнгөөр шууд болон шууд бус хэлбэрээр жинэ жил, баяр ёслолын аливаа арга хэмжээг зохион байгуулах, цаасан мэндчилгээ илгээх, баяр ёслол, ой тэмдэглэх зорилгоор бэлэг дурсгалын зүйлс, цүнх, календарь зэрэг зүйлс бэлтгэх, ивээн тэтгэхийг хориглох" зэрэг хууль, тогтоомж, заавар журмын заалтуудыг зөрчсөн байна. Үүнд:

Бараа үйлчилгээний бусад зардалтай холбоотой 54.7 сая төгрөгийн зөрчил илэрчээ.

- Төрийн албан хаагчдад олгосон 300.0 мянган төгрөгийн тэтгэмжийг 7 байгууллага сахилгын шийтгэлтэй 28 хүнд 7.0 сая төгрөгийг олгосон байна.
- Тэтгэмж урамшууллын болон хичээл үйлдвэрлэлийн зардлаас Хужирт сумын ЗДТГ, Уянга сумын ИТХ, Арвайхээр сумын 2 дугаар сургууль, Мэргэд сургууль, ХДТеатр, Хайрхандулаан сумын Соёлын төв зэрэг байгууллагууд 5.8 сая төгрөгийг тэмдэглэлт ой, баяр ёслол, бэлэг дурсгалын зүйлд зарцуулжээ.
 - Хайрхандулаан сумын ЕБС,
 - Арвайхээр сумын 4 дүгээр цэцэрлэг хичээл үйлдвэрлэлийн зардлаас 2017 оны 12 дугаар сарын 19-нд 1.0 сая төгрөгийг өглөгөөр бүртгэгдээгүй 2014 оны гадаад томилолтын зардал олгосон байна.
 - Сант сумын ЕБС, Бат-Өлзий сумын ИТХ, Төгрөг сумын Цэцэрлэг зэрэг байгууллагууд элэгдлийн зардлыг 34.2 сая төгрөгөөр буруу бүртгэсэн байна.
 - Бусад 6.7 сая төгрөгийн зардлыг үр дүнгийн тайланд илүү дутуу тусгасан.

Арван гурав.ОН-ийн өмчит үйлдвэрийн газрын бүртгэл, тайлагнал

13.1 ОНӨҮГ-ын бүтцийн талаар

ОН-ийн ТЕЗ-ийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд Онги Ус суваг ОНӨААТҮГ, Хархорин Ус суваг ОНӨААТҮГ, Арвайхээр тохижилт үйлчилгээний компани, 18 сумын ЭЭСангууд зэрэг 21 ОНӨААТҮГ-ын санхүүгийн тайлан нэгтгэгдсэн байна.

ОНӨҮГ-ын 2017 оны орлого, зарлага, хуримтлагдсан үр дүн

Хүснэгт 16
(сая төгрөгөөр)

ДД	Аймаг, Нийслэлийн нэр	Орлого	Зарлага	2017 оны үр дүн	Өмнөх үеийн үр дүн	Хуримтлагдсан үр дүн
1	Онги Ус суваг ОНӨААТҮГ	817.5	799.8	17.7	-114.9	-97.2
2	Хархорин Ус суваг ОНӨААТҮГ	164.9	164.3	0.6	15.5	16.1
3	Арвайхээр ТҮК	1007.6	1028.6	-21.0	-12.5	-33.5
4	ЭЭСангууд	366.6	338.1	28.5	-6.1	22.4
	Нийт	2356.6	2330.8	25.8	-118.0	-92.2

Дээрх аж ахуйн нэгжүүдээс Хархорин-Ус суваг ОНӨААТҮГ, ЭЭСангууд нийт дүнгээрээ ашигтай ажилласан байна.

ОНӨҮГ-дын 2017 оны санхүүгийн тайлангийн нэгтгэлээр мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 187.6 сая төгрөг, авлагын үлдэгдэл 146.2 сая төгрөг, бараа материалын үлдэгдэл 398.0 сая төгрөг, үндсэн хөрөнгийн үлдэгдэл 2270.9 сая төгрөг байна.

13.2 ОН-ын өмчит байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн талаар :

ОН-ийн өмчит байгууллагуудын санхүүгийн тайланд материаллаг 4.5 сая төгрөг, материаллаг бус 25.3 сая төгрөг, нийт 29.8 сая төгрөгийн алдаа зөрчил илэрч үүнээс 28.8 сая төгрөгийн алдаа зөрчлийг аудитын явцад залруулан бүртгэж, 1.0 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоон, мөнгөн дүнгүй 21 зөвлөмж өгсөн байна. Эдгээр алдаа зөрчлийн дүн нь дээрх дансуудаар задалсан дүнд орсон байгаа.

13.3 ОН-ийн ТЕЗ-ийн тайланд нэгтгэгдсэн төсөл, сангийн талаар

ОН-ын ТЕЗ-ийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд дараах сангууд нэгтгэгдсэн байна. Үүнд:

- Орон нутаг хөгжүүлэх сан
- Сум хөгжүүлэх сан зэрэг 2 сан нэгтгэгдсэн байна

13.4 Төсөл, сангуудын мөнгөн хөрөнгийн талаар

Сангуудын 2017 оны жилийн эцсийн мөнгөн хөрөнгийн үлдэгдлийг хүснэгтээр харуулбал :

Хүснэгт 17
(сая төгрөгөөр)

Д/Д	Сангийн нэр	Сантай /Сумын тоо/	Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл
1	Сум хөгжүүлэх сан	19	1060.3
2	ОНХСан	20	146.5
	ДҮН	39	1206.8

Сум хөгжүүлэх санд томоохон үлдэгдэлтэй сумдыг дурдвал:

- Хархорин 182.7 сая төгрөг
- Хужирт 121.4 сая төгрөг
- Богд 86.7 сая төгрөг
- Баян-Өндөр 86.5 сая төгрөг
- Бүрд 86.5 сая төгрөг
- Сант 80.1 сая төгрөг
- Бат-Өлзий 67.0 сая төгрөг
- Бусад сумдууд 15.0-35.2 сая хүртэлх төгрөгийн үлдэгдэлтэй байна..

Орон нутаг хөгжүүлэх санд томоохон үлдэгдэлтэй сумдууд:

- Төгрөг 31.7 сая төгрөг
- Хужирт 22.4 сая төгрөг
- Хайрхандулаан 21.9 сая төгрөг
- Өлзийт 17.1 сая төгрөг
- Гучин-Ус 16.1 с ая төгрөг
- Тарагт 11.0 сая төгрөг
- Бусад сумдууд 0.1-9.9 сая хүртэлх төгрөгийн үлдэгдэлтэй байна..

13.5 Төсөл, сангуудын авлага, өр төлбөрийн талаар

ОН-ийн тусгай сангуудын 2017 оны авлагын нийт үлдэгдэл 6167.3 сая төгрөг байна. Үүнд: Баян-Өндөр 243.4 сая төгрөг, Бүрд 247.3 сая төгрөг, Бат-Өлзий 232.0 сая төгрөг, ББУлаан 164.4 сая төгрөг, Баянгол 191.5 сая төгрөг, Гучин-Ус 210.6 сая төгрөг, Есөнзүйл 304.2 сая төгрөг, Өлзийт 322.1 сая төгрөг, ЗБУлаан 111.4 сая төгрөг, Хайрхандулаан 227.3 сая төгрөг, Нарийнтээл 219.1 сая төгрөг, Сант 297.9 сая төгрөг, Тарагт 244.0 сая төгрөг, Төгрөг 182.3 сая төгрөг, Уянга 381.3 сая төгрөг, Богд 210.4 сая төгрөг, Хужирт 397.2 сая төгрөг, Хархорин 995.4 сая төгрөг, Арвайхээр 985.5 сая төгрөг байна.

13.6 ОН-ын ТЕЗ-ийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар төсөл сангуудтай холбоотой гарсан зөрчлийн талаар

Төсөл сантай холбоотой нийт **114.6 сая төгрөгийн** зөрчил илэрч аудитаар 40.8 сая төгрөгийн алдааг залруулан, 73.7 сая төгрөгийн алдаа зөрчлийг залруулаагүй байна. залруулаагүй нийт алдаанаас 49.7 сая төгрөг нь материаллаг бол 24.0 сая төгрөг нь материаллаг бус байна. Зөрчлийг ангилбал:

- Баян-Өндөр, Зүүнбаян-Улаан, Төгрөг сумдын ОНХСан, Өлзийт, Зүүнбаян-Улаан сумдын Төрийн сангуудад 51.6 сая төгрөгийн хөрөнгө бүртгэлд тусгаагүй, зөрүүтэй бүртгэсэн, өр авлагад тусгаагүй зөрчил илэрсэн байна.
- Гучин-Ус, Баруунбаян-Улаан, Тарагт, Бат-Өлзий сумдын ОНХСангийн санхүүгийн тайланг зөрүүтэй илэрхийлсэн 25.8 сая төгрөгийн алдаа зөрчил илэрсэн байна.
- Нарийнтээл сумын цэцэрлэгийн сантехникийн засварт зарцуулах Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөнөөс 0.5 сая төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан
- Хайрхандулаан, Өлзийт сумдын ОНХСангаас ажил үйлчилгээний үнийг бүрэн шилжүүлээгүй байхад 12.7 сая төгрөгийг шууд зардлаар бүртгэсэн зөрчил илэрсэн байна.
 - Орон нутгийн халамжийн сангийн аудитаар олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний зардлаас санхүүжүүлэн ахмад настнуудад олгосон 24.0 сая төгрөгийн өртөгтэй 1000 ширхэг "дулаан баригч"-ийг олгохдоо баг тус бүрт хэдийг хуваарилсан тоо болон ямар шалгуурыг хангасан иргэдэд олгох заавар журам тодорхойгүй байна. Зарим багуудын тусламж олгосон жагсаалтын гарын үсэг дутуу, регистерийн дугаар, хаяг нь тодорхойгүй хүмүүст олгосон зэрэг зөрчлүүд байна.

Дээрх зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, 16.5.2-т “батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих;” гэсэн заалт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.”, 14 дүгээр зүйлийн 14.4.2 “бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлагыг заавал бүртгэнэ”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 “Төрийн өмчийн эд хөрөнгийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд заасан журмаар үнэлж бүртгэнэ.” заалтууд, СС-ын 2006 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн 388 дугаар тушаалаар батлагдсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын холбогдох заалтуудыг зөрчсөн байна.

Арван дөрөв. ОН-ийн тусгай шилжүүлгийн талаар

Төсвийн тухай хуулийн 61 дүгээр зүйлийн 61.1-д “Аймаг, Нийслэлийн Засаг дарга Засгийн газрын дараах чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлнэ” гэж заасан. Үүнд:

**ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН 2017 ОНЫ САНХҮҮГИЙН
НЭГТГЭСЭН ТАЙЛАНД ХИЙСЭН САНХҮҮГИЙН АУДИТ**

- Сургуулийн өмнөх боловсрол
- Ерөнхий боловсрол
- Соёлын үйлчилгээ
- Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ
- Хүүхдийн хөгжил, хамгааллын үйлчилгээ
- Нийтийн биеийн тамир

Үүний дагуу ЭМС, НХХС, БШУС, ССАЖС, ЗТБХБС-ын төсөвт батлагдсан тусгай зориулалтын шилжүүлгийг орон нутагт байршилтай харьяа байгууллагуудад нийт 45239.8 сая төгрөгийн санхүүжилтийг Төсвийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1-д заасны дагуу олгосон байна.

2017 онд тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын төсвийн гүйцэтгэлийн талаар хүснэгтээс харахад:

Хүснэгт 18
(сая.төгрөгөөр)

Үзүүлэлт	Нийт дүн	Үүнээс:				
		БШУ-ын сайд	НХХ-ын сайд	ЭМС-ын сайд	ССАЖ-ын сайд	ЗТБХБ-ын сайд
Батлагдсан төсөв	45240.0	38796.5	156.7	6055.3		231.5
Олгосон урсгал санхүүжилт	45239.8	38796.3	156.7	6055.3		231.5
Нийт төвлөрүүлсэн						
Үүнээс: Төсөвт /Сангийн яам/						

Тайлант онд тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилтэд 45240.0 сая төгрөг батлагдсанаас 45239.8 сая төгрөгийг олгосон байна.

Тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын хөрөнгийн задаргаа

Хүснэгт 19
(сая.төгрөгөөр)

Үзүүлэлт	2016 оны дүн	2017 оны дүн	Үүнээс:				
			БШУ-ын сайд	ЭМС-ын сайд	НХХ-ын сайд	ССАЖ-ын сайд	ЗТБХБ-ын сайд
Мөнгөн хөрөнгө	14.3	0.1		0.1			
Авлага	165.3	54.2	53.1	1.1			
Урьдчилгаа	40.0	64.0	64.0				
Бараа материал	3305.6	3590.1	3192.0	338.4	16.3		43.4
Нөөцийн бараа	383.0	420.4	314.5	105.9			
Үндсэн хөрөнгө	80678.6	85757.9	71089.4	13414.2	348.2		906.1
Нийт хөрөнгийн дүн	84586.8	89886.7	74713.0	13859.7	364.5		949.5
Өр төлбөр	291.2	97.1	74.8	21.9	0.4		
Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	84295.6	89789.6	74638.2	13837.8	364.1		949.5
Өр төлбөр цэвэр хөрөнгө/өмчийн дүн	84586.8	89886.7	74713.0	13859.7	364.5		949.5

Хүснэгтээс харахад нийт үндсэн хөрөнгө 5079.3 сая төгрөг, бараа материал 284.5 сая төгрөг, нөөцийн бараа 37.4 төгрөг, урьдчилгаа 24.0 сая төгрөгөөр тус тус өссөн бол авлага 111.1 сая төгрөг, өр төлбөр 194.2 сая төгрөгөөр буурсан байна.

**Арван тав. ОН-ийн төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн
тайланд хийсэн аудитын дүнгийн талаар**

ОН-ийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хамрагдсан ТТЗ, төсвийн байгууллагууд болон ОНӨААҮГ-ын санхүүгийн тайлангийн аудитаар **2131.9 сая** төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 728.0 сая төгрөгийн материаллаг, 587.3 сая төгрөгийн материаллаг бус алдааг залруулж, залруулагдаагүй 816.6 сая төгрөгийн алдаа зөрчилд 13.7 сая төгрөгийн 15 төлбөрийн акт, 180.0 сая төгрөгийн 39 албан шаардлага, 622,8 сая төгрөгийн алдаа, зөрчлийг арилгах 123 зөвлөмж өгсөн байна.

Аудитаар ОН-ийн төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн тайланд нэгтгэсэн төсвийн болон орон нутгийн өмчит аж ахуй нэгжийн 240 байгууллагаас 106 байгууллагад бие даасан дүгнэлт гаргаж, 88 байгууллага түүвэрт хамруулж, 46 байгууллагад итгэл үзүүлсэн байна.

Бие даасан дүгнэлт гаргасан 106 байгууллагаас 94 байгууллагад зөрчилгүй дүгнэлт өгсөн бол 12 байгууллагад хязгаарлалттай дүгнэлт өгсөн байна. Үүнд:

“Хязгаарлалттай” санал дүгнэлт авсан байгууллагын жагсаалт:

Хүснэгт 20

№	ОН-ийн төсвийн байгууллагууд	“Хязгаарлалттай” санал, дүгнэлтийн шалтгаан
1	Богд сумын ЭМТөв	ТШЗ-ийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд залруулах боломжгүй 11.6 сая төгрөгийн зөрчил илэрч албан шаардлага тавигдсан. Тухайлбал: <ul style="list-style-type: none"> Эмийн урвалж бодисийн 3.9 сая төгрөгийн эд хариуцагчийн тайлан гаргаагүй, анхан шатны баримтгүй, Дулаан богдын тун ХХК-тай 5.6 сая төгрөгийн шаардлагатай гэсэн эм солилцсон боловч зарцуулалтын жагсаалтаас өөр үндэслэх баримтгүй, солилцсон эмийн орлого зарлагыг тайланд тусгаагүйгээс эмийн нэр төрөл зөрсөн, Дулаан богдын тун ХХК нь бэлтгэн нийлүүлсэн эмийн зарлагын падаан бичиж өгдөггүй байна. 2.1 сая төгрөгийн төлбөрийн акт тавигдсан.
2	Бүрд сумын ЭМТөв	ТШЗ-ийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд залруулах боломжгүй 5.6 сая төгрөгийн зөрчил илэрч албан шаардлага тавигдсан. Тухайлбал: <ul style="list-style-type: none"> Батлагдсан орон тооноос хэтрүүлэн 1 хүнийг авч ажиллуулснаар 5.6 сая төгрөгийг цалингийн зардлаас зарцуулсан байгаа нь хэмжилт, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй байна.
3	Зүүнбаян-улаан сумын ИТХурал	ТШЗ-ийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд залруулах боломжгүй 1.2 сая төгрөгийн зөрчил илэрч албан шаардлага тавигдсан. Тухайлбал <ul style="list-style-type: none"> Санхүүгийн тайланд 0.4 сая төгрөгийн авлага, 0.6 сая төгрөгийн өглөг бүртгэсэн нь тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй 2015 оноос хойш эзэн тодорхойгүй санхүүгийн тайланд өглөг авлагаар бүртгэгдэж ирсэн, шуудан холбооны зардлаас гар утасны 0.2 сая төгрөгийн нэгж олгосон зэрэг зөрчлүүд нь санхүүгийн тайлангийн оршин байх, үнэн зөв илэрхийлэх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна
4	Хархорин сумын ИТХурал	ТШЗ-ийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд залруулах боломжгүй 6.2 сая төгрөгийн зөрчил илэрч албан шаардлага тавигдсан. Тухайлбал: <ul style="list-style-type: none"> 2017 оны 12 дугаар сард 5 ажилтанд тус бүр 1250.0 мянган төгрөг, нийт 6.2 сая төгрөгийн хоолны хөнгөлөлт олгосон нь Сангийн сайдын 2013 оны 73 дугаар тушаалын 4.1.5-д “Цалин хөлсний зардлыг бусад зардлын зүйлд шилжүүлэн зарцуулахгүй байх” гэсэн заалт

**ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН 2017 ОНЫ САНХҮҮГИЙН
НЭГТГЭСЭН ТАЙЛАНД ХИЙСЭН САНХҮҮГИЙН АУДИТ**

5	Уянга сумын ИТХурал	<p>ТШЗ-ийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд залруулах боломжгүй 1.4 сая төгрөгийн зөрчил илэрч албан шаардлага тавигдсан. Тухайлбал:</p> <ul style="list-style-type: none"> • Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, бараа үйлчилгээний бусад зардлаас 1.1 сая төгрөгийг ИТХ-ын 25 жилийн ойн баярын хүлээн авалтын зардалд зарцуулж, зардлыг зориулалт бусаар зарцуулсан байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дүгээр зүйлийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах"-ыг, УИХ-ын 29 дүгээр тогтоолын 1.2.е, 1.2.ё-г мөрдөж ажиллаагүй байна. • ИТХ-ын даргын захирамжаар 2017 оны 12 дугаар сарын 15-ны 02/13 тоот захирамжаар томилогдсон комисс хөрөнгийн тооллогыг хийсэн боловч тооллого явуулсан тухай илтгэх хуудас бичээгүй, тооцоо бодсон актаар баталгаажуулаагүй, мөн 0.3 сая төгрөгийн принтерийг тоололгүй орхигдуулсан байна. Эдгээр нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 73.2-д "Байгууллагын нягтлан бодогч нь үндсэн хөрөнгө, бараа материал, үнэ бүхий зүйлийн тооллогоор бэлэн байсан үлдэгдэл, гарсан зөрүүг тооллогын акт материал батлагдсанаас хойш 5 хоногийн дотор нягтлан бодох бүртгэлд тусгаж дансны үлдэгдлийг тулган шалгана" гэсэн заалтыг зөрчсөн байна
6	Хужирт сумын ЗДТГ	<p>ТШЗ-ийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд залруулах боломжгүй 51.1 сая төгрөгийн зөрчил илэрч албан шаардлага тавигдсан. Тухайлбал:</p> <ul style="list-style-type: none"> • Жилийн эцсээр 41.4 сая төгрөгийн мал, 2.0 сая төгрөгийн бусад хангамжийн материал, 4.7 сая төгрөгийн бичиг хэргийн материал, нийт 48.1 сая төгрөгийн бараа материалын тооллогын бүртгэл байхгүй байна. Энэ зөрчил нь завсрын аудитаар илэрч, зөвлөмж өгөгдсөн боловч зөрчлийг давтан гаргасан байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70. 2.-т ""түүхий эд, материал, түлш, сэлбэг хэрэгсэл, бэлэн бүтээгдэхүүн, бараа, сав, баглаа боодлын тооллогыг жилд 2 удаа хийнэ"" гэсэн заалтыг зөрчсөн. • Тайлант хугацаанд 2.0 сая төгрөгийн тавилга эд хогшил худалдан авсан, нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага үүссэний 25 жилийн ойн арга хэмжээнд 1.0 сая төгрөг зарцуулсан нь МУ-ын 2017 оны төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хууль батлагдсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай УИХ-ын 2017 оны 29 дүгээр тогтоолыг зөрчсөн.
7	Хужирт сумын Соёлын төв	<p>ТШЗ-ийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд залруулах боломжгүй 1.2 сая төгрөгийн зөрчил илэрч акт, албан шаардлага тавигдсан. Тухайлбал:</p> <ul style="list-style-type: none"> • Номын санч Б.Лхавгадуламд 0.2 сая төгрөгийн цалин илүү олгосон байгаа нь Төсвийн тухай хуулийн 6.4.8 дах "төсвийг зохистой удирдаж авлага, өр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1.3 "жинхэнэ хэрэгжилтийн" гэсэн заалтуудыг зөрчсөн. • Лүн шавдаг ХХК-аас ном худалдан авахаар 1.0 сая төгрөг шилжүүлж номыг нийлүүлээгүй байхад үндсэн хөрөнгөд бүртгэсэн байгаа нь Төсвийн тухай хуулийн 5.1.5 дэх "Хариуцлагатай байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.6 дахь заалтыг зөрчсөн.
8	Өлзийт сумын Соёлын төв	<p>ТШЗ-ийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд залруулах боломжгүй 2.9 сая төгрөгийн зөрчил илэрч албан шаардлага тавигдсан. Тухайлбал:</p> <ul style="list-style-type: none"> • Цалингийн зардлаас гэрээгээр түр ажилласан ажилтны хөлсөнд 2.9 сая төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.
9	Хайрхандулаан сумын Соёлын төв	<p>ТШЗ-ийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд залруулах боломжгүй 1.9 сая төгрөгийн зөрчил илэрч албан шаардлага тавигдсан. Тухайлбал:</p> <ul style="list-style-type: none"> • Санхүүгийн тайланд цалингийн хэмнэгдсэн зардлаас хөлсөөр ажиллах гэрээ байгуулан бүжгийн уран бүтээлийн санг нэмэгдүүлэх зорилгоор багш ажлуулсаны хөлсөнд 1.3 сая төгрөг олгосон, Сумын төвийн шинэ жилийн урлагын тоглолтын арга хэмжээний зардалд 0.6 сая төгрөг олгосон зэрэг зөрчлүүд нь санхүүгийн тайлангийн оршин байх, үнэн зөв илэрхийлэх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.
10	Тарагт багийн Туяа баг сургууль	<p>ТШЗ-ийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд залруулах боломжгүй 13.7 сая төгрөгийн зөрчил илэрч албан шаардлага тавигдсан. Тухайлбал:</p> <ul style="list-style-type: none"> • Санхүүгийн тайлан, нярвын тайлан эхний үлдэгдэл, орлого, зарлага, эцсийн үлдэгдэл зөрүүтэй 10.6 сая төгрөгөөр зөрүүтэй, 1.0 сая төгрөгийн шатах тослох материал, сэлбэг хэрэгсэл, барилгын материалын тайлан гаргаагүй байгаа нь үнэн зөв байх бодитоор

**ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН 2017 ОНЫ САНХҮҮГИЙН
НЭГТГЭСЭН ТАЙЛАНД ХИЙСЭН САНХҮҮГИЙН АУДИТ**

		<p>оршин байх батламж мэдэгдлийг хангаагүй.</p> <ul style="list-style-type: none"> Цалингийн зардал, хоолны зардлаас хэмнэгдсэн зардлыг бараа үйлчилгээний бусад зардал, бага үнэтэй түргэн элэгдэх зардалд Сангийн сайдын 2013 оны 73 дугаар тушаалын дагуу бүлэг хооронд шилжүүлсэн боловч нийт 2.1 сая төгрөгөөр хөлдөөгч, модом авч төсвийн зориулалт бусаар хэмнэлтгүй зарцуулсан байна.
11	Гучин-Ус сумын Төрийн сан	<p>ТЕЗ-ийн 2017 оны жилийн эцсийн нэгтгэсэн санхүүгийн тайланд залруулах боломжгүй 37.2 сая төгрөгийн зөрчил илэрч сумын ЗДТГ-т албан шаардлага тавигдсан. Тухайлбал:</p> <ul style="list-style-type: none"> Сумын ЗДТГ-ын машин тоног төхөөрөмжийн дансанд бүртгэлтэй 34.2 сая төгрөгийн өртөг бүхий “Япон дизль”, бусад үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй 3.0 сая төгрөгийн өртөг бүхий “цагаан хаалганы гэрэлтүүлэг” зэрэг үндсэн хөрөнгүүд 2017 оны жилийн эцсийн тооллогоор бодитоор оршин байхгүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6, 20.2.9, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 73 дугаар зүйлийн 73.2 дахь заалтуудыг тус тус зөрчсөн, мөн санхүүгийн тайлангийн аудитын “оршин байх” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй байна.
12	Хужирт сумын Төрийн сан	<p>ТЕЗ-ийн 2017 оны жилийн эцсийн нэгтгэсэн санхүүгийн тайланд залруулах боломжгүй 52.3 сая төгрөгийн зөрчил илэрч сумын ЗДТГ-т албан шаардлага тавигдсан. Тухайлбал:</p> <ul style="list-style-type: none"> Хужирт сумын төрийн сангийн нэгтгэсэн тайлан болон түүвэрт хамрагдсан орон нутгийн төсвийн 2 байгууллага ОНХСан, СХСангийн 2017 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар залруулагдаагүй материаллаг хэмжээний гэж үзсэн алдаа, зөрчил байхгүй ч бие даасан дүгнэлт гаргуулж хязгаарлалттай дүгнэлт авсан ЗДТГазар, СХТөвийн санхүүгийн тайланд залруулагдаагүй материаллаг хэмжээний 52319.6 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрч ЗДТГазарт завсарын аудитаар илэрсэн зөрчил дахин давтан гарсан, энэ нь бидний тооцоолсон материаллаг түвшингээс давсан байна.

Арван зургаа. Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт

ОН-ийн төсвийн байгууллагуудын 2016 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 172 зөвлөмж өгснөөс 100 хувийн биелэлттэ, албан шаардлагын биелэлт 70.4 хувь, актын биелэлт 95.2 хувьтай байгаа бол 59.7 сая төгрөгийн албан шаардлага, 0.4 сая төгрөгийн акт хэрэгжээгүй байна.

Арван долоо. Санхүүгийн нэгтгэсэн тайланд өгсөн санал, дүгнэлт

ОН-ийн ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитын гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2017 оны үр дүнгийн тайлангийн нийт зарлагыг материаллаг байдлын суурь болгон авч түүний 1.0 хувиар сонгон 1185.1 сая төгрөгөөр тогтоосон бөгөөд дараах нөхцөл байдлаас үзэхэд материаллаг хэмжээний залруулах боломжгүй 269.7 сая төгрөгийн зөрчил илэрсэн нь бидний тооцоолсон материаллаг түвшингээс бага байгаа учир “Зөрчилгүй” санал дүгнэлтийг санал болгож байна.

- ОН-ийн ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэгдсэн түүвэрт хамрагдсан 5 (Аймгийн ЗДТГ, БОАЖГазар, Санхүүгийн аудит дотоод хяналтын алба, Сум дундын ойн анги, ХДТеатр) байгууллагын санхүүгийн тайланд хийсэн аудитаар материаллаг хэмжээний залруулах боломжгүй 29.2 сая төгрөгийн алдаа зөрчил илэрч 4 зөвлөмж өгч, 0.6 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага өгсөн байна. /Хавсралт 1/
- Дээрх хязгаарлалттай дүгнэлт авсан төсвийн 10 байгууллагын санхүүгийн тайлан, 2 төрийн сангийн нэгтгэсэн санхүүгийн тайланд материаллаг 186.3 сая төгрөгийн алдаа зөрчлийг залруулах боломжгүй байна.

ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН 2017 ОНЫ САНХҮҮГИЙН
НЭГТГЭСЭН ТАЙЛАНД ХИЙСЭН САНХҮҮГИЙН АУДИТ

- Бусад байгууллагуудад залруулах боломжгүй материаллаг 51.2 сая төгрөгийн алдаа зөрчил илэрсэн байна.

Арван найм. Тайлант оны аудитын зөвлөмж

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтанд зөвлөж байна.

Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын дарга болон аймаг, сумдын Засаг дарга нарт:

1. Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 6 дугаар зүйлийн 6.4.8-д "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", 6 дугаар зүйлийн 16.5.5-д "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" 41.2.2 дахь " Батлагдсан төсвийн хүрээнд зардал гаргах" .

2. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно", 13.7 дахь "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 12 дугаар зүйлийн 12.2.1 дэх "жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг заавал хийнэ", 14 дүгээр зүйлийн 14.4 дэх "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ". 14.4.2 дахь "бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага бүртгэнэ".

3. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 73.2-д "Байгууллагын нягтлан бодогч нь үндсэн хөрөнгө, бараа материал, үнэ бүхий зүйлийн тооллогоор бэлэн байсан үлдэгдэл, гарсан зөрүүг тооллогын акт материал батлагдсанаас хойш 5 хоногийн дотор нягтлан бодох бүртгэлд тусгаж дансны үлдэгдлийг тулган шалгана".

4. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь "Төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгө нь төрийн болон орон нутгийн өмч байна" гэсэн дээрх хуулийн заалтуудын хэрэгжилтэнд хяналт тавих.

5. ОН-ийн ТТЗ-дын 2017 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилган аудитын зөвлөмж, акт, албан шаардлагын биелэлтийг ханган ажиллаж, дотоод хяналтыг сайжруулж ажиллах зөвлөмжийг өгч байна.

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР

Л.ЛАМААЧИН
Д.ГАНСҮХ

БЭЛТГЭСЭН:

АХЛАХ АУДИТОР
АУДИТОР
АУДИТОР

Ж.НЯМАА
Д.НАРАНТУЯА
Б.ЭРДЭНЭЦЭЦЭГ

2018.04.19